



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН  
ХӨГЖЛИЙН ГАЗАР

# “ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ОРЧИН”

*ЗАХИАЛГАТ СУДАЛГААНЫ ТАЙЛАН*

СУДАЛГААНЫ ЗАХИАЛАГЧ:

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

СУДАЛГААНЫ ГҮЙЦЭТГЭГЧ:

“ОНОЛ АРГА” ТББ

**УЛААНБААТАР. 2021**

## **АГУУЛГА**

<b>ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ</b> .....	2
<b>ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ</b> .....	2
<b>ГРАФИКАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ</b> .....	3
<b>ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ</b> .....	3
<b>1. УДИРТГАЛ</b> .....	6
СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ .....	6
СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ .....	6
СУДАЛГААНЫ АРГА .....	7
<b>2. ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ОРЧИН СУДАЛГААНЫ ТАЙЛАН</b> .....	8
2.1 СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ .....	8
2.2 ЭРҮҮЛ АМЬДРАХ ОРЧНЫ ТАЛААРХ ҮНЭЛГЭЭ .....	10
2.3 СЭТГЭЛЗҮЙН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ .....	17
2.4 АЮУЛГҮЙ АМЬДРАХ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ .....	22
2.5 СУРЧ ХӨГЖИХ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ .....	29
2.6 ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЛЦЭЭТ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ .....	34
<b>ДҮГНЭЛТ САНАЛ ЗӨВЛӨМЖ</b> .....	39

## ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Судалгааны линкний зураг .....	7
Зураг 2. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээлэл .....	8
Зураг 3. Амьдардаг сууцны төрөл .....	8
Зураг 4. Хүүхдэд ээлтэй орчны үнэлгээ .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Зураг 5. Эрүүл амьдрах орчны үнэлгээ .....	10
Зураг 6. Сэтгэлзүйн орчны үнэлгээ .....	17
Зураг 7. Аюулгүй амьдрах орчны үнэлгээ .....	22
Зураг 8. Сурч хөгжих орчны үнэлгээ .....	29
Зураг 9. Эдийн засгийн хүрэлцээт орчны үнэлгээ .....	34

## ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Түүврийн хэмжээ .....	6
Хүснэгт 2. Эх олонлогийн хэмжээ .....	6
Хүснэгт 3. Мэдээлэл цуглуулалтын тоо .....	7
Хүснэгт 4. Түүврийн хэмжээ дүүргээр .....	9
Хүснэгт 5. Эрүүл амьдрах орчин – дүүргүүдийн харьцуулалт .....	10
Хүснэгт 6. Эрүүл мэндийн үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт .....	11
Хүснэгт 7. Хөгжлийн орчин үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт .....	12
Хүснэгт 8. Ногоон байгууламжийн үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт .....	13
Хүснэгт 9. Агаарын бохирдолын үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт .....	14
Хүснэгт 10. Хөрсний бохирдолын үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт .....	15
Хүснэгт 11. Ундны усны үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт .....	16
Хүснэгт 12. Сэтгэлзүйн орчин – дүүргүүдийн харьцуулалт .....	17
Хүснэгт 13. Интернет, гар утасны үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт .....	18
Хүснэгт 14. Архи, согтууруулах ундаа, мансууруулах бодсын үзүүлэлт – Дүүргүүдийн харьцуулалт .....	19
Хүснэгт 15. Харилцааны үзүүлэлт – Дүүргүүдийн харьцуулалт .....	20
Хүснэгт 16. Хүчирхийллийн үзүүлэлт – Дүүргүүдийн харьцуулалт .....	21
Хүснэгт 17. Аюулгүй амьдрах орчин – дүүргүүдийн харьцуулалт .....	22
Хүснэгт 18. Гэрэлтүүлгийн үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт .....	23
Хүснэгт 19. Гэрэлтүүлгийн үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт .....	24
Хүснэгт 20. Хаягжилтийн үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт .....	25
Хүснэгт 21. Нийтийн тээврийн үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт .....	26
Хүснэгт 22. Замын хөдөлгөөний үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт .....	27
Хүснэгт 23. Хүүхэд хамгааллын үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт .....	28
Хүснэгт 24. Сурч хөгжих орчин – дүүргүүдийн харьцуулалт .....	29
Хүснэгт 25. Спорт заалны үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт .....	30
Хүснэгт 26. Тоглоомын талбайн үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт .....	31
Хүснэгт 27. Тоглоомын талбайн үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт .....	33
Хүснэгт 28. Эдийн засгийн хүрэлцээт орчин – дүүргүүдийн харьцуулалт .....	34
Хүснэгт 29. Өрхийн орлогын үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт .....	35
Хүснэгт 30. Хүнсний үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт .....	36
Хүснэгт 31. Бичиг хэргийн үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт .....	37
Хүснэгт 32. Хувцас солих үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт .....	38

## ГРАФИКАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

График 1. Эрүүл мэнд -Дүүргүүдийн харьцуулалт .....	11
График 2. Хоггүй орчин -Дүүргүүдийн харьцуулалт .....	12
График 3. Ногоон байгууламж -Дүүргүүдийн харьцуулалт .....	13
График 4. Агаарын бохирдол -Дүүргүүдийн харьцуулалт.....	14
График 5. Хөрсний бохирдол -Дүүргүүдийн харьцуулалт .....	15
График 6. Ундны ус -Дүүргүүдийн харьцуулалт.....	16
График 7. Интернет, гар утас -Дүүргүүдийн харьцуулалт.....	18
График 8. Архи, согтууруулах ундаа, мансууруулах бодис -Дүүргүүдийн харьцуулалт.....	19
График 9. Харилцаа - Дүүргүүдийн харьцуулалт.....	20
График 10. Хүчирхийлэл - Дүүргүүдийн харьцуулалт .....	21
График 11. Гэрэлтүүлэг - Дүүргүүдийн харьцуулалт .....	23
График 12 . Гэрэлтүүлэг - Дүүргүүдийн харьцуулалт .....	24
График 13 . Хаягжилт - Дүүргүүдийн харьцуулалт.....	25
График 14. Нийтийн тээвэр - Дүүргүүдийн харьцуулалт .....	26
График 15. Замын хөдөлгөөн - Дүүргүүдийн харьцуулалт .....	27
График 16. Хүүхэд хамгаалал - Дүүргүүдийн харьцуулалт .....	28
График 17. Спорт заал - Дүүргүүдийн харьцуулалт.....	30
График 18. Тоглоомын талбай - Дүүргүүдийн харьцуулалт .....	31
График 19. Тоглоомын талбай - Дүүргүүдийн харьцуулалт .....	32
График 20. Өрхийн орлого - Дүүргүүдийн харьцуулалт.....	35
График 21. Хүнс - Дүүргүүдийн харьцуулалт .....	36
График 22. Бичиг хэрэг - Дүүргүүдийн харьцуулалт .....	37
График 23. Солих хувцас - Дүүргүүдийн харьцуулалт .....	37

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БАГАНУУР	БНД
БАГАХАНГАЙ	БХД
БАЯНГОЛ	БГД
БАЯНЗҮРХ	БЗД
НАЛАЙХ	НД
СОНГИНОХАЙРХАН	СХД
СҮХБААТАР	СБД
ХАНУУЛ	ХУД
ЧИНГЭЛТЭЙ	ЧД

## ТОВЧ ХУРААНГУЙ

Улаанбаатар хотын хүүхдүүдийн амьдарч буй орчин нөхцөлийг хүүхдэд ээлтэй эсэхийг тодорхойлох зорилгын хүрээнд нийт 9 дүүргийн 8-17 насны 4094 хүүхдийг төлөөлүүлэн, онлайн судалгааны программаар санамсаргүй түүврийн аргад тулгуурлан цахим хэлбэрээр зохион байгуулсан. Судалгааны мэдээлэл цуглуулалтын чанар, бодитой байдлыг хангахын тулд 2 удаагийн чанарын хяналт хийн, чанарын шаардлага хангаагүй, эргэлзээтэй 276 мэдээллийг судалгааны үр дүнгээс хасч, мэдээллийг үнэн бодитой, дүүргүүдийг төлөөлөх чадвартай хэмээн тооцон судалгааны үр дүнг нэгтгэн боловсруулсан билээ.

Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээллийг авч үзвэл эмэгтэй- 58.9%, эрэгтэй – 41.1%, 8-13 насныхан - 60.1%, 14-17 насныхан - 39.9% тус тус эзэлж байна. Хүүхдүүдийн 61.9% нь буюу 3 хүүхэд тутмын 2 нь орон сууцанд амьдардаг бол 35.2% нь гэр хороололд амьдардаг байна.

Хүүхдэд ээлтэй орчинг тодорхойлохын тулд Казахстан улсын туршлагад тулгуурлан эдийн засгийн орчин, сэтгэлзүйн орчин, сурч хөгжих орчин, эрүүл амьдрах орчин, аюулгүй амьдрах орчин гэсэн нийт үндсэн 5 үзүүлэлт, 24 дэд үзүүлэлт, 93 асуулгаар хэмжсэн. Үндсэн 5 үзүүлэлтээс Сурч хөгжих орчин **42%**, Эрүүл амьдрах орчин **55%**, Сэтгэл зүйн орчин **57%**, Аюулгүй амьдрах орчин **59%**, Эдийн засгийн хүрэлцээт орчин **80%**-ийн үзүүлэлттэй буюу хүүхдэд ээлтэй орчин нийтдээ Улаанбаатар хотын хэмжээнд **59%** буюу Саарал бүсэд багтаж байна. Энэ нь хүүхдүүдийн хувьд амьдарч буй орчин нөхцөл нь ээлтэй байж чадахгүй, асуудалтай цаашид анхаарах шаардлагатай байгааг илтгэж байна.

Эрүүл амьдрах орчны хувьд хамгийн эрсдэлтэй нөлөөлөгч хүчин зүйл нь Хогний асуудал гэж гарсан. Харин дараагийн чухал зайлшгүй анхаарах шаардлагатай хүчин зүйлсүүд нь агаарын бохирдол, ногоон байгууламж, хөрсний бохирдол, эрүүл мэндийн асуудлууд байна. Энэ нь хүүхдүүд эрүүл амьдрах орчин нөхцөл хангалтгүй байгааг илэрхийлж байна.

Сэтгэлзүйн орчны хувьд хамгийн эрсдэлтэй нөлөөлөгч хүчин зүйлс нь Мансууруулах бодис, Харилцааны асуудал гэж гарсан. Харин дараагийн чухал зайлшгүй анхаарах шаардлагатай хүчин зүйлс нь Хүчирхийллийн асуудал байна. Энэ нь хүүхдүүд сэтгэл зүйн хувьд эрсдэлгүй амьдрах орчин нөхцөл хангалтгүй байгааг харуулж байна.

Аюулгүй амьдрах орчны хувьд хамгийн эрсдэлтэй нөлөөлөгч хүчин зүйлс нь Нийтийн тээвэр, Хаягжилтын асуудал гэж гарсан. Харин дараагийн чухал зайлшгүй анхаарах шаардлагатай хүчин зүйлс нь Хүүхэд хамгааллын асуудал байна. Энэ нь хүүхдүүд аюулгүй амьдрах орчин нөхцөлийн хувьд эрсдэлтэй бүлэг хамаарч байгаа судалгаанаас харагдаж байна.

Сурч хөгжих орчны хувьд хамгийн эрсдэлтэй нөлөөлөгч хүчин зүйлс нь Тоглоомын талбай гэж гарсан. Харин дараагийн чухал зайлшгүй анхаарах шаардлагатай хүчин зүйлс нь Боловсрол,

Спорт заалны асуудал гэж гарсан. Энэ нь хүүхдүүд сурч хөгжих хангалттай орчин нөхцөлд амьдарч чадахгүй байгаа нь харагдаж байна.

Эдийн засгийн хүрэлцээт орчны хувьд бусад үзүүлэлттээ бодвол харьцангуй орчин нөхцөл нь эрсдэлтэй багатай боломжийн түвшинд гарсан.

Энэ бүхнээс дүгнээд үзэхэд хүүхдүүдийн хувьд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх тохь тухтай эрүүл, аюулгүй, сэтгэл зүйн дарамтгүй орчин нөхцөлийг хүсдэг ч манай улсын хувьд хүүхдүүдэд ээлтэй орчинг бүрдүүлж чадахгүй саарал бүсэд байгаа нь харагдаж байна. Саарал бүс маань хар бүсрүү шилжих өндөр эрсдэлтэй учраас цаашид үзүүлэлт болгонд нөлөөлж байгаа хүчин зүйлсүүд дээр анхаарч ажиллан хүүхдэд ээлтэй орчинг бий болгох шаардлагатай байна.

## 1. УДИРТГАЛ

### СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэхүү судалгааг Улаанбаатар хотод амьдарч буй хүүхдүүдийн орчин, нөхцлийг судлан тэдний өсөлт хөгжилд ээлтэй байгаа эсэхийг үнэлэх зорилгоор хийж байна.

### СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Улаанбаатар хотын 9 дүүрэгт амьдарч буй 8-17 хүртэлх насны хүүхдүүдийг төлөөлүүлэн, Монгол улсын 2021 оны хүн ам зүйн статистик мэдээлэлд үндэслэн түүврийн хэмжээг тооцсон болно.

Хүснэгт 1. Түүврийн хэмжээ

Нас	Эх олонлог	Түүврийн хэмжээ			
		Нас	Хүйс		
			Эрэгтэй	Эмэгтэй	Нийт
8-12 нас	155 309	2 275	1 115	1 160	2 275
13-17 нас	95 700	1 395	683	711	1 395
	<b>251 009</b>	<b>3 670</b>	<b>1 798</b>	<b>1 872</b>	<b>3 670</b>

Судалгаанд оролцох хүүхдүүдийн түүврийн хэмжээг тооцоолон гаргахад 8-12 насны 2275 хүүхэд, 13-17 насны 1395 хүүхдүүдээс буюу нийт 3670 хүүхдээс судалгаа авах тооцоолол гарсан бөгөөд хүйсийн хувьд 49% нь эрэгтэй, 51% нь эмэгтэй байхаар төлөвлөсөн.

Хүснэгт 2. Эх олонлогийн хэмжээ

Дүүргүүд	Эх олонлог		Түүрийн хэмжээ		
	Тоо	Эзлэх хувь	Нийт	8-12 нас	13-17 нас
Багануур	5 110	2,1	<b>100</b>	62	38
Багахангай	729	0,3	<b>40</b>	25	15
Баянгол	38 134	15,2	<b>535</b>	332	203
Баянзүрх	61 142	24,3	<b>696</b>	432	264
Налайх	7 128	2,8	<b>160</b>	99	61
Сонгинохайрхан	56 447	22,5	<b>882</b>	547	335
Сүхбаатар	23 958	9,5	<b>408</b>	253	155
Хануул	33 140	13,2	<b>452</b>	280	172
Чингэлтэй	25 221	10,1	<b>397</b>	246	151
Нийт тоо	<b>251 009</b>	<b>100</b>	<b>3 670</b>	<b>2 275</b>	<b>1 395</b>

Дээрх тооцооллын дагуу дүүргүүдэд хувьчлан тооцож, дүүрэг бүрт хамаарах хороонуудаар түүврийн хэмжээг нарийвчлан гаргасан бөгөөд хамгийн хүн ам ихтэй Баянгол, Баянзүрх, Сонгино-Хайрхан дүүргүүдээс бусад дүүрэгтэй харьцуулахад илүү их хүүхэд хамрагдах төлөвлөлт гарсан.


## СУДАЛГААНЫ АРГА

Зорилтот түүврийн хэмжээг эх олонлогын 1% ийг эзлэхээр тооцон нийт 3 670 хүүхдийг хамруулахаар судалгааг онлайн программд оруулан, цахим хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд нийт 4 370 хүүхэд хамрагдсанаас алдаатай түүврийг хасч тооцон 4 094 хүүхдийн судалгааг зорилтот түүврийн хэмжээг бүрэн хангасанд тооцож, судалгааны мэдээллийг боловсруулан дүн шинжилгээ хийсэн болно.

Зураг 1. Судалгааны линкний зураг болон үнэлгээний аргачлал

Хувь	Агуулга	Өнгө
0-25	Маш муу	Хөнгөн сэрүү
26-45	Хангалтгүй	Хөнгөн
46-65	Дунд	Сэрүү
66-85	Боломжийн	Сэрүүн
86-100	Сайн	Сэрүүн

Судалгааны үнэлгээг 0-100% хувь дотор дээрх агуулга, өнгөний хувилбараар илэрхийлсэн болно.



Судалгааны мэдээлэл цуглуулалтыг дүүрэг тус бүрээр доорхи хүснэгтээр харуулж байна. Баянгол дүүрэг төлөвлөсөн түүврийн хэмжээнээс давуулан биелүүлсэн бол Баянзүрх, Сонгино-Хайрхан дүүрэг төлөвлөсөн түүврийн хэмжээндээ хүрч чадаагүй байна.

Хүснэгт 3. Мэдээлэл цуглуулалтын тоо

Дүүрэг	Түүврийн хэмжээ	Мэдээлэл цуглуулсан тоо
Багануур	100	134
Багахангай	40	51
Баянгол	535	1077
Баянзүрх	696	543
Налайх	160	185
Сонгинохайрхан	882	268
Сүхбаатар	408	565
Хан-Уул	452	591
Чингэлтэй	397	680
<b>Нийт тоо</b>	<b>3670</b>	<b>4094</b>




## 2. ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ОРЧИН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

### 2.1 СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ


Улаанбаатар хотод 8-17 насны нийт 251 009 хүүхэд амьдарч байгаа<sup>1</sup> бөгөөд насны хувьд 62% нь 8-13 насныхан, 49% нь эрэгтэй хүүхэд байна гэсэн статистик тоон мэдээлэлд үндэслэн эх олонлогыг судалгааны хамрах хүрээнд нарийвчлан дурьдсаны дагуу тодорхойлсон бөгөөд судалгаанд оролцсон хүүхдүүдийн нас болон хүйсийн харьцааг авч үзэхэд эх олонлогыг төлөөлөх бүрэн чадвартай болох нь харагдаж байна.

Зураг 2. Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээлэл



Судалгаа маань санамсаргүй түүврийн аргад тулгуурласан учир амьдардаг сууцны хэлбэрийг нарийвчлан тооцоолох боломжгүй байсан бөгөөд нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 61,9% нь буюу ойролцоогоор 3 хүүхэд тутмын 2 нь орон сууцанд амьдардаг бол 35,2% нь гэр хороололд амьдардаг байна.

Зураг 3. Амьдардаг сууцны төрөл





















Харин судалгааны мэдээлэл цуглуулсан дүүргүүдийн хувьд цаг үеийн нөхцөл байдлаас хамааран, хүүхдийн хичээл онлайнаар орж байсан, бүртгэл болон мэдээлэл хангалтгүй, орон зайн хүчин зүйлстэй холбоотой хүндрэл учирч Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдийн түүвэр төлөвлөгдсөн хэмжээндээ хүрээгүй, Баянгол дүүргийн түүвэр хэмжээнээс хэтэрсэн гэсэн

<sup>1</sup> Хүн ам зүйн статистик 2021

нөхцөл байдал үүссэн бөгөөд судалгааны үнэн бодитой байдлыг хангахын тулд 2 удаагийн чанарын хяналт хийн, чанарын шаардлага хангаагүй, эргэлзээтэй 276 мэдээллийг судалгааны үр дүнгээс хасч, мэдээллийг үнэн бодитой, дүүргүүдийг төлөөлөх чадвартай хэмээн тооцон судалгааны үр дүнг нэгтгэн боловсруулсан билээ.

Хүснэгт 4. Түүврийн хэмжээ дүүргээр


Дүүргүүд		Эх олонлогт эзлэх хувь	Түүвэрт эзлэх хувь
 Баянгол		15.2%	<b>26.3%</b>
 Чингэлтэй		10.1%	16.6%
 Хан-Уул		13.2%	14.4%
 Сүхбаатар		9.5%	13.8%
 Баянзүрх		24.3%	<b>13.3%</b>
 Сонгинохайрхан		22.5%	<b>6.5%</b>
 Налайх		2.8%	4.5%
 Багануур		2.1%	3.3%
 Багахангай		0.3%	1.2%

Хүүхдэд ээлтэй орчинг тодорхойлохын тулд эдийн засгийн орчин, сэтгэлзүйн орчин, сурч хөгжих орчин, эрүүл амьдрах орчин, аюулгүй амьдрах орчин гэсэн үндсэн 5 үзүүлэлтээр нийт 24 дэд үзүүлэлтээр хэмжсэн.

## 2.1 ЭРҮҮЛ АМЬДРАХ ОРЧНЫ ТАЛААРХ ҮНЭЛГЭЭ

Хүүхдүүдийн эрүүл амьдрах орчин нөхцөлийг үнэлэхдээ доорх 6 дэд бүлгийн хүрээнд хэмжиж үнэлсэн. Судалгаагаар **55%** буюу эрүүл амьдрах орчин нөхцөл таатай биш асуудалтай байгаа нь доорх байшингийн цонхоор илэрхийлэгдсэн өнгийн дүрслэлээс харж болно.

Зураг 4. Эрүүл амьдрах орчны үнэлгээ



Эрүүл амьдрах орчинд хамгийн их сөргөөр нөлөөлж байгаа үзүүлэлт бол “Хогний асуудал” болох нь цонхонд хар саарал өнгөөр дүрслэгдсэнээр харагдаж байна. Хүүхдүүдийн хүрээлэн буй орчин хог ихтэй, энд тэндгүй замбараагүй байдал ихтэй байгаа учраас зайлшгүй эхний ээлжинд хогний асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Мөн цаашлаад Агаарын бохирдолыг бууруулах, Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, Хөрсний бохирдолыг багасгах асуудлыг анхаарч ажиллахгүй бол хүүхэд багачуудын эрүүл амьдрах орчин нөхцөлд нь эдгээр асуудал хурцаар хөндөгдөж, өдөр тутамдаа нөлөөлж байдаг болох нь судалгааны үр дүнд гарсан.

Хүснэгт 5. Эрүүл амьдрах орчин – дүүргүүдийн харьцуулалт


Үнэлгээний үзүүлэлтүүд		Дүүргүүд									
		БНД	БХД	НД	БГД	СХД	СБД	БЗД	ЧД	ХУД	Нийт
1	Эрүүл мэнд	67%	68%	67%	62%	65%	64%	66%	65%	67%	<b>65%</b>
	Хоггүй орчин	50%	45%	45%	43%	40%	39%	41%	42%	45%	<b>42%</b>
	Ногоон байгууламж	50%	71%	44%	56%	51%	50%	49%	53%	62%	<b>54%</b>
	Агаарын бохирдол	54%	60%	42%	49%	46%	48%	45%	45%	49%	<b>47%</b>
	Хөрсний бохирдол	52%	47%	44%	54%	50%	51%	50%	52%	58%	<b>52%</b>
	Ундны ус	73%	69%	67%	70%	66%	68%	66%	68%	69%	<b>68%</b>
<b>Эрүүл амьдрах орчин</b>		<b>58%</b>	<b>60%</b>	<b>52%</b>	<b>56%</b>	<b>53%</b>	<b>53%</b>	<b>53%</b>	<b>54%</b>	<b>58%</b>	<b>55%</b>

Хүүхдүүд эрүүл амьдрах орчин нөхцөлийн хувьд бүх дүүргүүд саарал бүсэд багтаж байна. Энэ нь хүүхдүүдийн эрүүл амьдрах орчины асуудал нь анхаарал татахуйц хэмжээнд байгаагаас гадна цаашид зайлшгүй нөлөөлж байгаа хүчин зүйлсүүдэд нь анхаарч ажиллан, сайжруулах шаардлагатай байна. Налайх дүүргийн хувьд бусад дүүргүүдээсээ үзүүлэлтээрээ хамгийн бага үнэлгээтэй гарсан байна.

## 1. ЭРҮҮЛ МЭНД:

Эрүүл амьдрах гол хүчин зүйлсийн нэг болох “Эрүүл мэнд”-ийн асуудлын хувьд нийт дүүргүүдийн дундаж **65%**, шар бүсэд багтаж байна. Хамгийн бага хувьтай нь Баянгол дүүрэг 62%-тай байгаа бол хамгийн өндөр нь Багахангай 68%-тай байна.

График 1. Эрүүл мэнд - Дүүргүүдийн харьцуулалт



Эмчийн зааварчилгаагүйгээр дур мэдэн эм хэрэглэх хэрэглээ өндөртэй, ДОХ болон бэлгийн замын халдварт өвчлөлийн талаарх хангалттай мэдлэггүйгээс ирээдүйд хүүхэд залуучуудад үүсэх эрсдэл өндөр байгааг харуулж байна. Мөн цаашлаа иоджуулсан давс хэрэглээг нэмэгдүүлэх шаардлагатай болохыг илтгэж байна. Харин хүүхдүүдээ нэмэлт дархлаажуулалтын бүтээгдэхүүн хэрэглүүлэх, өвдсөн үедээ эмнэлэгт очиж үзүүлэх, өрхийн эмнэлгийн тусламж авах гэх мэт нэн шаардлагатай эрүүл мэндийн арга хэмжээнүүдийг өдөр тутамдаа хэвшүүлж чадаж байгаа нь судалгааны үр дүнд гарсан.

Хүснэгт 6. Эрүүл мэндийн үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт

№	Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
1	Иоджуулсан давсны хэрэглээ	69%	69%	80%	62%	74%	77%	70%	69%	73%	69%
2	Өвдсөн үедээ эмнэлэгт үзүүлдэг байвал	89%	82%	94%	90%	89%	73%	88%	88%	90%	92%
3	Өрхийн эмнэлгийн тусламж авдаг байдал	70%	72%	76%	67%	72%	73%	69%	67%	70%	75%
4	Эмчийн зааварчилгаагүй эм уудаггүй байдал	37%	38%	35%	30%	39%	44%	39%	35%	44%	36%
5	Хүүхдийн дархлаажуулалтыг бүтээгдэхүүн хэрэглэдэг байдал	83%	85%	92%	82%	81%	86%	84%	84%	85%	82%
6	ДОХ-ийн талаарх мэдлэгтэй байдал	41%	54%	29%	40%	40%	47%	42%	43%	42%	36%
<b>Нийт дундаж</b>		<b>65%</b>	<b>67%</b>	<b>68%</b>	<b>62%</b>	<b>66%</b>	<b>67%</b>	<b>65%</b>	<b>64%</b>	<b>67%</b>	<b>65%</b>

Тиймээс цаашид хүүхэд багачуудад эрүүл мэндийн зөв хэвшил, төлөвшлүүдийг бий болгох шаардлагатай байна. Үүнд:

- Эмчийн зааваргүйгээр дуран мэдэн эм хэрэглэх байдлын хор уршгийг сургууль болон гэр бүлийн хүрээнд сайн ойлгуулж, эрүүл мэндийн хичээл дээр нөлөөллийн ажлыг хэрэгжүүлэх
- ДОХ болон бэлгийн замын халдварт өвчний талаар огт мэдээлэлгүй учраас өсвөр насныхан дунд замбараагүй бэлгийн хавьтлын тохиолдол их байх магадлалтай учраас бэлгийн замын


халдварт өвчний хор уршиг, түүнээс гарах сөрөг үр дагавар, хамгаалалт хэрэглэх талаар эрүүл мэндийн хичээлээр дамжуулан 14-дээш насныханд тогтмол орж байх

- Ойджүүлсан давсны ашиг тусыг гэр бүлийн гишүүдэд сурталчлах, цаашид үүсч болох үр нөлөөг сурагчдад таниулах арга хэмжээ зохион байгуулах

## 2. ХОГГҮЙ ОРЧИН:

Эрүүл амьдрах гол хүчин зүйлсийн нэг болох “Хог”-ийн асуудлын хувьд нийт дүүргүүдийн дундаж **42%**, хар бүсэд буюу эрсдэлтэй гэсэн хэсэгт багтаж байна. Хамгийн бага хувьтай нь Сонгино-хайрхан дүүрэг 40%, Баянзүрх дүүрэг 41% -тай байгаа бол хамгийн өндөр нь Багануур 50%-тай байна.

График 2. Хоггүй орчин - Дүүргүүдийн харьцуулалт



Ил задгай хог хаягдал их байдаг нь хүүхэд багачуудын дунд эрүүл мэндийн эрсдэл өндөр байгааг харуулж байна. Энэ нь нийтийн эзэмшлийн хогийн савны хүрэлцээ бага байгаатай шууд хамааралтай бөгөөд нөгөө талаас хогоо ил задгай хаяхгүй байх иргэдийн хандлагаас хамаарч байна. Мөн цаашлаад 3 хүүхэд тутмын 2 нь хог ангилж хаядаггүй нь ангилж хаях суурь орчин нөхцөл бүрдээгүй, иргэдийн дунд ангилж хаях сэтгэл зүйн төлөвшил хангалттай бий болоогүйгээс шалтгаалж байна.

Хүснэгт 7. Хоггүй орчин үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт

№	Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
1	Хогоо ангилж хаядаг байдал	39%	51%	33%	42%	38%	35%	34%	38%	41%	37%
2	Нийтийн эзэмшлийн хогийн савны хүрэлцээтэй байдал	60%	72%	69%	61%	57%	63%	58%	56%	58%	62%
3	Ил задгай хог хаягдал байдаггүй байдал	28%	26%	33%	26%	26%	38%	29%	24%	36%	27%
<b>Нийт дундаж</b>		<b>42%</b>	<b>50%</b>	<b>45%</b>	<b>43%</b>	<b>41%</b>	<b>45%</b>	<b>40%</b>	<b>39%</b>	<b>45%</b>	<b>42%</b>

Тиймээс цаашид хүүхэд багачуудыг эрүүл хоггүй орчинд байлгахын тулд дараах зүйлсийг хийх шаардлагатай байна. Үүнд:

- Өрх гэр бүл, сургуулийн орчинд хогоо ангилж хаях, ил задгай хог хаяхгүй байх зөв дадлыг бий болгохын тулд иргэн бүр өөрсдөө манлайлан бусаддаа шаардлага тавьдаг байх, ангилсан


хогийг ачих болон дахин ашиглалтын боломжийг холбогдох төрийн байгууллагаас зохион байгуулж ажиллах.

- Ил задгай хог хаягдал бууруулахын тулд нийтийн эзэмшлийн хогийн савны хүрэлцээг нэмэгдүүлэхийн тулд сум хөгжүүлэх сангийн санал хураалтад саналаа оруулж, өөрсдөө гамтай хэрэглэх, харуул хамгаалалтаа сайжруулах зэрэгт анхаарч ажиллах.

### 3. НОГООН БАЙГУУЛАМЖ:

Эрүүл амьдрах гол хүчин зүйлсийн нэг болох “Ногоон байгууламж”-ийн асуудлын хувьд нийт дүүргүүдийн дундаж **54%**, саарал бүсэд буюу анхаарал татахуйц хэсэгт багтаж байна. Хамгийн бага хувьтай нь Налайх дүүрэг 44% бол хамгийн өндөр нь Багахангай 71%-тай байна.

График 3. Ногоон байгууламж -Дүүргүүдийн харьцуулалт



Нийтийн эзэмшлийн талбайд чөлөө цагаа өнгөрөөх, агаарын бохирдлоос сэргийлэх, эрүүл орчинд бүрдүүлэх ногоон байгууламж бага байдаг нь эрүүл мэндийн хувьд эрсдэл өндөр байгааг харуулж байна. Мөн цаашлаад 2 хүүхэд тутмын 1-д нь ойр орчимд нь ногоон байгууламж байдаггүй байна. Гэртээ цэцэг тарьж ногоон орчинг бүрдүүлэх явдал 69% буюу хангалттай түвшинд байж чаддаггүй болох нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Хүснэгт 8. Ногоон байгууламжийн үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт

№	Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
1	Гэртээ цэцэг тарьдаг байдал	69%	57%	63%	76%	69%	57%	68%	69%	69%	68%
2	Амьдардаг орчинд ногоон байгуулж байдаг байдал	52%	55%	71%	57%	44%	41%	49%	48%	59%	51%
3	Ногоон байгууламжтай нийтийн эзэмшлийн талбайтай байдал	39%	36%	78%	34%	34%	33%	35%	34%	58%	42%
<b>Нийт дундаж</b>		<b>54%</b>	<b>50%</b>	<b>71%</b>	<b>56%</b>	<b>49%</b>	<b>44%</b>	<b>51%</b>	<b>50%</b>	<b>62%</b>	<b>53%</b>

Тиймээс цаашид ногоон байгууламж бүхий орчинг бий болгохын тулд дараах зүйлсийг хийх шаардлагатай байна. Үүнд:


- Гэртээ болон амьдардаг ойр орчиндоо ногоон байгууламж бий болгох, түүнийг арчлах, ашиг тусыг нь ойлгуулах чиглэлээр хөдөлмөрийн хичээл дээр нь сургалт орж, жил бүр тухайн тарьсан ногоон байгууламжийг дахин хичээлийн ашиглалтанд оруулж, эргэх холбоог хангах

- Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, иргэдийн ногоон байгууламжийг хайрлах, цаашид арчлах арга замуудыг зааж өгч, дэмжлэг үзүүлэх, харуул хамгаалалттай болох

#### 4. АГААРЫН БОХИРДОЛ:

Эрүүл амьдрах гол хүчин зүйлсийн нэг болох “Агаарын бохирдол”-ийн асуудлын хувьд нийт дүүргүүдийн дундаж **47%**, хар бүсэд буюу эрсдэлтэй гэсэн хэсэгт багтаж байна. Хамгийн бага хувьтай нь Налайх дүүрэг 42% бол хамгийн өндөр нь Багахангай 60%-тай байна.

График 4. Агаарын бохирдол - Дүүргүүдийн харьцуулалт



Хүүхдүүдийн ойр орчимд нь утаа угаар их үнэртдэг болохыг 5 хүүхэд тутмын 4 нь судалгаагаар илэрхийлсэн байдал нь эрүүл мэндийн хувьд эрсдэл өндөртэй байгааг харуулж байна. Мөн цаашлаад агаарын бохирдол ихтэй байгаагаас агаар цэвэршүүлэгчийг хэр ашиглаж байгааг тодорхойлоход 3 хүүхэд тутмын 1 нь гэртээ, ангидаа 2 хүүхэд тутмын 1 нь агаар цэвэршүүлэгч ашигладаг гэж гарсан.

Хүснэгт 9. Агаарын бохирдолын үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт

№	Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
1	Гэртээ тамхи татдаггүй байдал	80%	81%	90%	85%	76%	58%	79%	79%	80%	81%
2	Утаа угаар үнэртдэггүй байдал	21%	21%	61%	20%	21%	23%	15%	16%	34%	15%
3	Гэртээ агаар цэвэршүүлэгч ашигладаг байдал	31%	22%	20%	35%	31%	37%	35%	29%	29%	31%
4	Ангидаа агаар цэвэршүүлэгч ашигладаг байдал	57%	93%	69%	54%	51%	52%	54%	70%	54%	53%
<b>Нийт дундаж</b>		<b>47%</b>	<b>54%</b>	<b>60%</b>	<b>49%</b>	<b>45%</b>	<b>42%</b>	<b>46%</b>	<b>48%</b>	<b>49%</b>	<b>45%</b>


Тиймээс цаашид агаарын бохирдлыг бууруулж эрүүл орчинг бий болгохын тулд дараах зүйлсийг хийх шаардлагатай байна. Үүнд:

- Улсын хэмжээнд агаарын бохирдол ихтэй байгаа учраас гэр бүлийн хүрээнд өөрсдийн бололцоогоороо сайжруулсан түлш хэрэглэх, агаар цэвэршүүлэгч ашиглах байдлаа илүү нэмэгдүүлэх
- Нөгөө талаас улс орны хувьд агаарын бохирдолыг багасгах үр дүнтэй аргуудыг хэрэглэж, эрүүл амьдрах орчинг иргэддээ бүрдүүлэх шаардлагатай байна.

## 5. ХӨРСНИЙ БОХИРДОЛ:

Эрүүл амьдрах гол хүчин зүйлсийн нэг болох “Хөрсний бохирдол”-ийн асуудлын хувьд нийт дүүргүүдийн дундаж **52%**, саарал бүсэд буюу анхаарал татахуйц хэсэгт багтаж байна. Хамгийн бага хувьтай нь Налайх дүүрэг 44% бол хамгийн өндөр нь Хан-уул дүүрэг 58%-тай байна.

График 5. Хөрсний бохирдол - Дүүргүүдийн харьцуулалт



Бохироо соруулдаггүй шууд хөрсөндөө шингэдэг уламжлалт ОО-ыг 2 өрх тутмын 1 ашиглаж байгаа нь хөрсний бохирдолд маш их эрсдэлийг бий болгож байна. Мөн үүнээс гадна муу усны нүх цооноггүй байдлаас шалтгаалан ил задгай угаадас асгах, түүнийгээ дагаад бохирын үнэр үнэртэх явдал нэлээд байгаа нь хөрсний бохирдолын асуудалд зайлшгүй анхаарах шаардлагатай болохыг харуулж байна.

Хүснэгт 10. Хөрсний бохирдолын үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт

№	Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
1	ОО-ийн бохирдолын байдал	33%	23%	13%	30%	24%	35%	32%	35%	39%	38%
2	Муу усны нүх, цооног байдаг байдал	63%	69%	44%	68%	59%	56%	59%	60%	71%	65%
3	Ил задгай угаадас асгадаггүй байдал	53%	54%	63%	58%	50%	35%	58%	43%	64%	46%
4	Бохир үнэртдэггүй байдал	61%	61%	71%	61%	66%	48%	50%	65%	60%	61%
<b>Нийт дундаж</b>		<b>52%</b>	<b>52%</b>	<b>47%</b>	<b>54%</b>	<b>50%</b>	<b>44%</b>	<b>50%</b>	<b>51%</b>	<b>58%</b>	<b>52%</b>

Тиймээс цаашид хөрсний бохирдолыг бууруулж эрүүл орчинг бий болгохын тулд дараах зүйлсийг хийх шаардлагатай байна. Үүнд:


- Гэр хороололд амьдарч байгаа өрх гэрүүдийг ОО-ын бохирыг соруулдаг шийдлээр нэмэгдүүлэх



## 6. УНДНЫ УС:

Эрүүл амьдрах гол хүчин зүйлсийн нэг болох “Ундны ус”-ны асуудлын хувьд нийт дүүргүүдийн дундаж **68%**, саарал бүсэд буюу анхаарал татахуйц хэсэгт багтаж байна. Хамгийн бага хувьтай нь Баянзүрх, Сонгино-хайрхан дүүрэг 66% бол хамгийн өндөр нь Багануур дүүрэг 73%-тай байна.

График 6. Ундны ус -Дүүргүүдийн харьцуулалт



Гэртээ ус цэвэршүүлэгч, шүлтүүр ашиглах байдал хангалттай биш дээрээс нь ундны усаа зориулалтын саванд хадгалж, хэрэглэх байдал 2 өрх тутмын 1-д байгаа нь өрх гэрүүд ундны усны зөв хэрэглээнд хангалттай очоогүй болохыг харуулж байна. Нөгөө талаас сургууль дээрээ ус цэвэршүүлэгч ашиглах байдал харьцангуй өндөр буюу 84% байна.

Хүснэгт 11. Ундны усны үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт

№	Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
1	Ундны усны зориулалтын савтай байдал	65%	75%	82%	57%	66%	83%	65%	69%	62%	71%
2	Гэртээ ус цэвэршүүлэгч, шүлтүүр ашигладаг байдал	56%	51%	55%	62%	55%	49%	53%	51%	60%	51%
3	Сургуульдаа ус цэвэршүүлэгч, шүлтүүр ашигладаг байдал	84%	93%	69%	90%	78%	70%	81%	84%	85%	83%
<b>Нийт дундаж</b>		<b>68%</b>	<b>73%</b>	<b>69%</b>	<b>70%</b>	<b>66%</b>	<b>67%</b>	<b>66%</b>	<b>68%</b>	<b>68%</b>	<b>68%</b>


Тиймээс цаашид ундны ус зөв хэрэглээгээр эрүүл орчинг бий болгохын тулд дараах зүйлсийг хийх шаардлагатай байна. Үүнд:

- Усаа зориулалтын саванд хийж хадгалах, цаашлаад ус цэвэршүүлэгч болон шүлтүүр ашиглах хэвшлийг бий болгох

## 2.2 СЭТГЭЛЗҮЙН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ

Хүүхдүүдийн сэтгэл зүйн орчин нөхцөлийг үнэлэхдээ доорх 4 дэд бүлгийн хүрээнд хэмжиж үнэлсэн. Судалгаагаар **57%** буюу сэтгэл зүйн орчин нөхцөл таатай биш асуудалтай байгаа нь доорх байшингийн цонхоор илэрхийлэгдсэн өнгийн дүрслэлээс харж болно.

Зураг 5. Сэтгэлзүйн орчны үнэлгээ



Сэтгэл зүйн орчинд сөргөөр нөлөөлж байгаа үзүүлэлт бол “Мансууруулах бодис, Харилцааны асуудал” болох нь цонхонд саарал өнгөөр дүрслэгдсэнээр харагдаж байна. Хүүхдүүдийн интернет, гар утасны хэрэглээ бусад үзүүлэлтээсээ харьцангуй боломжийн түвшинд байгааг шар өнгөөр илэрхийлэгдсэнээс харж болохоор байна.

Хүснэгт 12. Сэтгэлзүйн орчин – дүүргүүдийн харьцуулалт


Үнэлгээний үзүүлэлтүүд	Дүүргүүд									
	БНД	БХД	НД	БГД	СХД	СБД	БЗД	ЧД	ХУД	Нийт
1 Интернет, гар утас	69%	74%	59%	76%	74%	73%	73%	73%	74%	<b>73%</b>
2 Мансууруулах бодис	50%	49%	41%	54%	51%	51%	49%	51%	55%	<b>52%</b>
3 Хүчирхийлэл	57%	55%	41%	55%	57%	52%	58%	56%	56%	<b>55%</b>
4 Харилцаа	56%	53%	57%	52%	53%	52%	52%	50%	53%	<b>52%</b>
<b>Нийт дундаж</b>	<b>58%</b>	<b>58%</b>	<b>50%</b>	<b>59%</b>	<b>59%</b>	<b>57%</b>	<b>58%</b>	<b>58%</b>	<b>60%</b>	<b>57%</b>

Хүүхдүүд сэтгэл зүйн орчин нөхцөлийн хувьд бүх дүүргүүд саарал бүсэд багтаж байна. Энэ нь хүүхдүүдийн сэтгэл зүйн орчины асуудал нь анхаарал татахуйц хэмжээнд байгаагаас гадна цаашид зайлшгүй нөлөөлж байгаа хүчин зүйлсүүдэд нь анхаарч ажиллан, сайжруулах шаардлагатай байна. Налайх дүүргийн хувьд бусад дүүргүүдээсээ үзүүлэлтээрээ хамгийн бага үнэлгээтэй гарсан байна.

## 1. ИНТЕРНЕТ, ГАР УТАС:

Сэтгэл зүйн орчны гол хүчин зүйлсийн нэг болох “Интернет, гар утас”-ийн хувьд нийт дүүргүүдийн дундаж **73%**, шар бүсэд буюу боломжийн түвшинд хамаарч байна. Хамгийн бага хувьтай нь Налайх дүүрэг **59%**-тай байгаа бол хамгийн өндөр нь Баянгол **76%**-тай байна.

График 7. Интернет, гар утас -Дүүргүүдийн харьцуулалт



Интернет болон ухаалаг утас ашиглах тал дээр хангалттай түвшинд байгаа бөгөөд эцэг эхчүүдийн зүгээс холбогдох хяналтуудыг хийдэг ч хүүхдүүдийн хувьд өдөр тутам цахим орчинд тогтмол байх явдал их байгаа нь ирээдүйд хүүхэд залуучуудад цахим орчинд донтох эрсдэл өндөр байгааг харуулж байна.

Хүснэгт 13. Интернет, гар утасны үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт

№	Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
1	Суурин интернет хэрэглэдэг байдал	80%	68%	73%	91%	75%	71%	77%	76%	82%	77%
2	Ухаалаг утас ашигладаг байдал	88%	93%	88%	90%	86%	74%	87%	92%	89%	86%
3	Өдөр тутам цахим орчинд онлайн байдаггүй байдал	31%	24%	35%	31%	35%	31%	32%	29%	30%	35%
4	Гар утас хэрэглээнд нь хяналт тавигддаг байдал	84%	79%	86%	85%	85%	66%	88%	83%	85%	86%
5	Интернет хэрэглээнд хяналт тавигддаг байдал	83%	80%	88%	84%	86%	56%	85%	84%	84%	83%
<b>Нийт дундаж</b>		<b>73%</b>	<b>69%</b>	<b>74%</b>	<b>76%</b>	<b>73%</b>	<b>59%</b>	<b>74%</b>	<b>73%</b>	<b>74%</b>	<b>73%</b>


Тиймээс цаашид интернет, гар утасны зөв хэрэглээг бий болгохын тулд дараах зүйлсийг хийх шаардлагатай байна. Үүнд:

- Цахим хичээлээс бусад үед интернет, ухаалаг утасны хэрэглээнд эцэг эхүүд илүү их хяналт тавиж, зөв зохистой хэрэглээг бий болгох

## 2. АРХИ, СОГТУУРУУЛАХ УНДАА, МАНСУУРУУЛАХ БОДИС:

Сэтгэл зүйн орчны гол хүчин зүйлсийн нэг болох “Архи, согтууруулах ундаа, мансууруулах бодис”-ийн хувьд нийт дүүргүүдийн дундаж **52%**, саарал бүсэд буюу анхаарал татахуйц хэсэгт багтаж байна. Хамгийн бага хувьтай нь Налайх дүүрэг 41%-тай байгаа бол хамгийн өндөр нь Хан-Уул 55%-тай байна.

График 8. Архи, согтууруулах ундаа, мансууруулах бодис - Дүүргүүдийн харьцуулалт



Хүүхдүүдийн хувьд мансууруулах бодисын талаарх мэдлэг хомстой болох судалгааны үр дүнгээс харагдаж байна. Мөн найз нөхөд, үе тэнгийнхэн нь архи болон согтууруулах ундаа хэрэглэсэн тохиолдол 35% нь байгаа гэж хариулснаас харахад тодорхой хэмжээнд архины хэрэглээ байдаг байна. Замд нь архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн хүмүүс таардаг байдал харьцангуй өндөр байгаа нь иргэдийн дунд архидалт их хүүхдүүд сэтгэл зүйн хувьд тэднээс айж эмээх асуудал гардаг байх магадлалтай. Ойр орчмынх нь мансууруулах бодис хэрэглэдэг тохиолдол гарч байсан гэж 6% нь хариулсан байсан бөгөөд Налайх дүүргийн хувьд 30%-тай байгаа нь цаашид энэ чиглэлд зайлшгүй анхаарч хүүхэд залуучуудаа зөв амьдралын хэвшилд төлөвшүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 14. Архи, согтууруулах ундаа, мансууруулах бодисын үзүүлэлт – Дүүргүүдийн харьцуулалт

№	Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
1	Хүүхэд архи болон согтууруулах ундаа хэрэглэдэггүй байдал	65%	57%	59%	67%	68%	37%	65%	66%	65%	69%
2	Замд нь архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн хүмүүс таардаггүй байдал	27%	25%	31%	28%	26%	25%	24%	24%	39%	24%
3	Мансууруулах бодисын талаар мэддэг байдал	39%	40%	27%	43%	30%	45%	38%	38%	40%	38%
4	Ойр орчим мансууруулах бодис хэрэглэдэггүй байдал	75%	77%	78%	79%	72%	57%	77%	78%	76%	74%
<b>Нийт дундаж</b>		<b>52%</b>	<b>50%</b>	<b>49%</b>	<b>54%</b>	<b>49%</b>	<b>41%</b>	<b>51%</b>	<b>51%</b>	<b>55%</b>	<b>51%</b>


Тиймээс цаашид мансууруулах бодисны хэрэглээг бууруулахын тулд дараах зүйлсийг хийх шаардлагатай байна. Үүнд:

- Архи, согтууруулах ундаа болон мансууруулах бодисын хэрэглээг бууруулахын тулд эцэг эхийн хяналт тогтмол хийх, хүүхдүүдээ зөв үлгэрлэл, зөв хэрэглээний талаарх ойлгуулж, хор ушгийг таниулах ажиллааг хийх

### 3. ХАРИЛЦАА:

Сэтгэл зүйн орчны гол хүчин зүйлсийн нэг болох “Харилцаа”-ны хувьд нийт дүүргүүдийн дундаж **52%**, саарал бүсэд буюу анхаарал татахуйц хэсэгт багтаж байна. Хамгийн бага хувьтай нь Баянгол, Баянзүрх, Сүхбаатар дүүргүүд 52%-тай байгаа бол хамгийн өндөр нь Налайх 57%-тай байна.

График 9. Харилцаа - Дүүргүүдийн харьцуулалт



Хүүхдүүд өөрийн үзэл бодлоо бүрэн дүүрэн илэрхийлж чаддаггүй мөн эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс боломжийн түвшинд сонсож чаддаг гэж хариулсан байна. Сургуулийн орчинд багш ажилтнууд сурагчдын үзэл бодлыг сонсох, ижил тэгш харилцдаг байдал хангалтгүй байдаг байна. Харин сургуульд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүндэлж, ижил тэгш харьцдаг байдал маш хангалтгүй ялгаварлан гадуурхалт бүх дүүрэгт нэлээдгүй байгааг 3 хүүхэд тутмын 1 нь хүлээн зөвшөөрч байсан.

Хүснэгт 15. Харилцааны үзүүлэлт – Дүүргүүдийн харьцуулалт

№	Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
1	Өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чаддаг байдал	51%	51%	47%	49%	54%	55%	57%	45%	52%	51%
2	Эцэг эх, асран хамгаалагчид нь үзэл бодлыг сонсдог байдал	76%	68%	84%	75%	77%	82%	74%	75%	75%	76%
3	Сургуульд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүндэлж, ижил тэгш харьцдаг байдал	38%	51%	35%	34%	38%	41%	35%	41%	38%	38%
4	Сургуулийн багш, ажилчид сурагчдын үзэл бодлыг сонсдог	58%	65%	67%	60%	54%	58%	58%	60%	59%	53%
5	Сургуулийн багш, ажилтнууд хүүхэд бүртэй адил тэгш харилцдаг байдал	51%	56%	51%	52%	49%	52%	54%	52%	52%	48%
6	Нийгмийн харилцаанд өөрийн дуу хоолойг илэрхийлдэг байдал	40%	46%	31%	39%	38%	58%	42%	38%	41%	36%
<b>Нийт дундаж</b>		<b>52%</b>	<b>56%</b>	<b>53%</b>	<b>52%</b>	<b>52%</b>	<b>57%</b>	<b>53%</b>	<b>52%</b>	<b>53%</b>	<b>50%</b>


Тиймээс цаашид харилцааны сөрөг асуудлыг бууруулахын тулд дараах зүйлсийг хийх шаардлагатай байна. Үүнд:

- Эцэг эх хүүхдүүдтэйгээ нээлттэй ярилцах, үзэл бодлыг нь сайн сонсож байхаас гадна сургуулийн орчинд өөрийгөө илэрхийлэх боломжийг нь бүрдүүлэх шаардлагатай
- Нөгөө талаас ялгаварлан гадуурхалтыг аль түвшинд байлгахгүйн тулд зөв хүн байх төлөвшил хүмүүжлийн сургалт, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулж, гаргасан алдаа дутагдалд хариуцлага тооцдог байх эрх тэгш системийг нэвтрүүлэх

#### 4. ХҮЧИРХИЙЛЭЛ

Сэтгэл зүйн орчны гол хүчин зүйлсийн нэг болох “Хүчирхийлэл”-ийн хувьд нийт дүүргүүдийн дундаж **55%**, саарал бүсэд буюу анхаарал татахуйц хэсэгт багтаж байна. Хамгийн бага хувьтай нь Налайх 41%-тай байгаа бол хамгийн өндөр нь Баянзүрх 58%-тай байна.

График 10. Хүчирхийлэл - Дүүргүүдийн харьцуулалт



Сургуулийн орчимд нэгнийгээ үг хэлээр гутаан доромжлох, нэгнийгээ зодож, гэмтээх болон дээрэлхдэг байдал их болох судалгааны үр дүнгээс харагдаж байна. Бие биенээ сургууль дээр дээрэлхдэг байдал Баянгол, Налайх дүүргүүдэд илүү гардаг байна. Харин үг хэлээр гутаан доромжлох тохиолдол Налайх, Сүхбаатар, Хан-уул, Баянгол дүүрэгт их байдаг бол нэг нэгнийгээ зодож гэмтээх байтал Сүхбаатар, Чингэлтэй, Багахангай, Баянгол дүүргүүдэд нэлээд байна. Нөгөө талаас сургуулийн орчноос гадна үг хэлээр доромжлох, зодож гэмтээх байдал бас нэлээдгүй байдаг болохыг харж болохоор байна.

Хүснэгт 16. Хүчирхийллийн үзүүлэлт – Дүүргүүдийн харьцуулалт

№	Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
1	Сургууль дээр хүүхдүүд бие биенээ дээрэлхдэггүй байдал	37%	46%	37%	36%	39%	28%	40%	35%	36%	38%
2	Хэн нэгэн үг хэлээр гутаан доромжлох тохиолдол гардаггүй байдал	51%	52%	41%	52%	54%	39%	54%	43%	53%	54%
3	Сургуулийн орчимд хэн нэгнийг үг хэлээр гутаан доромжлох тохиолдол гардаггүй байдал	29%	29%	31%	29%	35%	12%	32%	25%	27%	30%
4	Хэн нэгэн зодож гэмтээдэггүй байдал	82%	80%	84%	83%	83%	66%	84%	82%	82%	85%

5	Сургуулийн орчимд хэн нэгнийг зодож, гэмтээх тохиолдол гардаггүй байдал	37%	45%	39%	36%	42%	34%	40%	33%	37%	34%
6	Биеийн нууц хэсэгт хэн нэгэн зөвшөөрөлгүй хүч хэрэглэн хүрсэн тохиолдол гардаггүй байдал	89%	87%	90%	90%	92%	58%	92%	88%	91%	92%
7	Сургуулийн орчимд хэн нэгний биед зөвшөөрөл, хүч хэрэглэн хүрсэн тохиолдол гардаггүй байдал	60%	58%	65%	61%	61%	52%	57%	59%	64%	57%
<b>Нийт дундаж</b>		<b>55%</b>	<b>57%</b>	<b>55%</b>	<b>55%</b>	<b>58%</b>	<b>41%</b>	<b>57%</b>	<b>52%</b>	<b>56%</b>	<b>56%</b>


Тиймээс цаашид хүчирхийллийн асуудлыг бууруулахын тулд дараах зүйлсийг хийх шаардлагатай байна. Үүнд:

- Сургуулийн орчинд хараа хяналт сайн тавих, хариуцлагын системийн тодорхой хатуу тогтоох, хийгдсэн үйл ажиллагаануудыг сургуулийн орчинд мэдээллэдэг байх
- Эцэг эхийн зүгээс үр хүүхэдтэй зөв боловсон харьцах, хараа хяналттай байлгах, байнгын ярилцан асуудлуудыг нь сонсож байх

### 2.3 АЮУЛГҮЙ АМЬДРАХ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ

Хүүхдүүдийн аюулгүй амьдрах орчин нөхцөлийг үнэлэхдээ доорх 6 дэд бүлгийн хүрээнд хэмжиж үнэлсэн. Судалгаагаар **59%** буюу аюулгүй амьдрах орчин нөхцөл таатай биш асуудалтай байгаа нь доорх байшингийн цонхоор илэрхийлэгдсэн өнгийн дүрслэлээс харж болно.

Зураг 6. Аюулгүй амьдрах орчны үнэлгээ



Аюулгүй орчинд сөргөөр нөлөөлж байгаа үзүүлэлт бол “Нийтийн тээвэр, Хаягжилт, Хүүхэд хамгаалал” болох нь цонхонд хар, саарал өнгөөр дүрслэгдсэнээр харагдаж байна. Харин замын хөдөлгөөн, гэрэлтүүлэг, цахилгаан дулаан нь бусад үзүүлэлтээсээ харьцангуй боломжийн түвшинд байгааг шар өнгөөр илэрхийлэгдсэнээс харж болохоор байна.

Хүснэгт 17. Аюулгүй амьдрах орчин – дүүргүүдийн харьцуулалт

Үнэлгээний үзүүлэлтүүд	Дүүргүүд									
	БНД	БХД	НД	БГД	СХД	СБД	БЗД	ЧД	ХУД	Нийт
1 Гэрэлтүүлэг	57%	66%	67%	73%	72%	67%	66%	68%	68%	<b>70%</b>
2 Цахилгаан, дулаан	65%	72%	51%	64%	68%	63%	69%	65%	69%	<b>65%</b>
3 Хаягжилт	45%	47%	43%	41%	40%	37%	33%	45%	45%	<b>41%</b>


4	Нийтийн тээвэр	42%	29%	43%	48%	47%	47%	43%	46%	40%	<b>45%</b>
5	Замын хөдөлгөөн	87%	82%	76%	90%	87%	86%	78%	86%	87%	<b>86%</b>
6	Хүүхэд хамгаалал	54%	58%	62%	50%	55%	48%	49%	51%	52%	<b>51%</b>
<b>Нийт дундаж</b>		<b>58%</b>	<b>59%</b>	<b>57%</b>	<b>61%</b>	<b>61%</b>	<b>58%</b>	<b>56%</b>	<b>60%</b>	<b>61%</b>	<b>59%</b>

Хүүхдүүдийн аюулгүй орчин нөхцөлийн хувьд бүх дүүргүүд саарал бүсэд багтаж байна. Энэ нь хүүхдүүдийн аюулгүй орчины асуудал нь анхаарал татахуйц хэмжээнд байгаагаас гадна цаашид зайлшгүй нөлөөлж байгаа хүчин зүйлсүүдэд нь анхаарч ажиллан, сайжруулах шаардлагатай байна. Баянзүрх дүүргийн хувьд бусад дүүргүүдээсээ үзүүлэлтээрээ хамгийн бага үнэлгээтэй гарсан байна.

## 1. ГЭРЭЛТҮҮЛЭГ

Аюулгүй орчны гол хүчин зүйлсийн нэг болох “Гэрэлтүүлэг”-ийн хувьд нийт дүүргүүдийн дундаж **70%**, шар бүсэд буюу боломжийн түвшинд хамаарч байна. Хамгийн бага хувьтай нь Багануур дүүрэг 57%-тай байгаа бол хамгийн өндөр нь Баянгол болон Хан-Уул дүүрэг нар 73%-тай байна.

График 11. Гэрэлтүүлэг - Дүүргүүдийн харьцуулалт



Хүүхдүүдийн хувьд хичээлээ хийх ширээний гэрэлтүүлэг харьцангуй боломжийн түвшинд байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Нөгөө талаас амьдрах орчны гэрэлтүүлэг, амьдардаг хорооны гудамж талбайн гэрэлтүүлгүүдийн хувьд 2 хүүхэд тутмын 1 нь бүрэн хангалттай тусдаггүй гэсэн байна.

Хүснэгт 18. Гэрэлтүүлгийн үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт

№	Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
1	Хичээлээ хийх ширээний гэрэлтэй байдал	77%	75%	75%	80%	76%	70%	77%	80%	74%	75%
2	Амьдрах орчинд гэрэлтүүлэг байдаг байдал	68%	48%	61%	72%	65%	67%	68%	64%	75%	65%
3	Гудамж талбайд гэрэлтүүлэг байдаг байдал	64%	48%	63%	66%	58%	64%	72%	58%	71%	65%
<b>Нийт дундаж</b>		<b>70%</b>	<b>57%</b>	<b>66%</b>	<b>73%</b>	<b>66%</b>	<b>67%</b>	<b>72%</b>	<b>67%</b>	<b>73%</b>	<b>68%</b>

Тиймээс цаашид гэрэлтүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд дараах зүйлсийг хийх шаардлагатай байна. Үүнд:




- Нийтийн гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, байнгийн ажиллагааг хангах засвар үйлчилгээг хийж байх

## 2. ЦАХИЛГААН ДУЛААН

Аюулгүй орчны гол хүчин зүйлсийн нэг болох “Цахилгаан дулаан”-ийн хувьд нийт дүүргүүдийн дундаж **65%**, саарал буюу дунд түвшинд хамаарч байна. Хамгийн бага хувьтай нь Налайх дүүрэг **51%**-тай байгаа бол хамгийн өндөр нь Багахангай **72%**-тай байна.

График 12 . Гэрэлтүүлэг - Дүүргүүдийн харьцуулалт



Хүүхдүүд гэрт нь тог цахилгаан тасардаг гэж **55%** үзсэнээс харахад цахилгааны хувьд асуудалтай байдаг нь харагдаж байна. Нөгөө талаас гэртээ даардаг гэж 8 хүүхэд тутмын 1, ангидаа даардаг гэж 4 хүүхэд тутмын 1 нь тийм хариулснаас харахад хүүхдүүдийн дунд даарахгүй тав тухтай амьдрах орчин нөхцөл нь хэсэг бүлэг хүүхдүүдийн дунд зөрчигдөж байна.

Хүснэгт 19. Гэрэлтүүлгийн үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт

Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
Тог цахилгаан гэрт нь тасардаггүй байдал	40%	45%	61%	42%	40%	36%	40%	31%	44%	39%
Гэртээ даардаггүй байдал	85%	83%	90%	84%	86%	69%	86%	86%	87%	85%
Ангидаа даардаггүй байдал	71%	67%	65%	66%	80%	47%	77%	71%	75%	72%
<b>Нийт дундаж</b>	<b>65%</b>	<b>65%</b>	<b>72%</b>	<b>64%</b>	<b>69%</b>	<b>51%</b>	<b>68%</b>	<b>63%</b>	<b>69%</b>	<b>65%</b>


Тиймээс цаашид цахилгаан дулааны хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд дараах зүйлсийг хийх шаардлагатай байна. Үүнд:

- Гэртээ болон ангидаа даарахгүй тухтай хичээллэх, амьдрах орчин нөхцөлийг нь аль аль талаасаа бүрдүүлж өгөх

### 3. ХАЯГЖИЛТ

Аюулгүй орчны гол хүчин зүйлсийн нэг болох “Хаягжилт”-ийн хувьд нийт дүүргүүдийн дундаж **41%**, хар бүсэд буюу эрсдэлтэй бүлэгт багтаж байна. Хамгийн эрсдэл өндөртэй нь Баянзүрх дүүрэг бол бусад дүүргүүдээсээ арай бага эрсдэлтэй нь Багахангай байна.

График 13. Хаягжилт - Дүүргүүдийн харьцуулалт



Хүүхдүүд төөрсөн үедээ гудамж талбайн хаягжилтыг ойлгож, ашиглаж чаддаггүй гэж бүгд хариулсан байна. Мөн амьдарч буй гудамж, талбай бүрэн хаягжилт 68%, амьдардаг хороо нийтийн эзэмшлийн гудамж талбайн хаягжилт 56% байдаг эсэх дээр тийм гэж хариулснаас харахад хаягжилт хүүхдүүдэд ойлгомжтой биш, бүрэн дүүрэн хаягжиж чадаагүй нь харагдаж байна.

Хүснэгт 20. Хаягжилтийн үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт

Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
Амьдарч буй гудамж, байр бүрэн хаягжилттай байдал	68%	73%	75%	70%	55%	63%	65%	64%	72%	73%
Амьдардаг хороо, нийтийн эзэмшлийн гудамж, талбай бүрэн хаягжилттай байдал	56%	63%	67%	54%	43%	66%	56%	48%	62%	63%
Төөрсөн үедээ гудамж талбайн хаягжилтийг ойлгож, ашиглаж чаддаг байдал	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%	0%
<b>Нийт дундаж</b>	<b>41%</b>	<b>45%</b>	<b>47%</b>	<b>41%</b>	<b>33%</b>	<b>43%</b>	<b>40%</b>	<b>37%</b>	<b>45%</b>	<b>45%</b>


Тиймээс цаашид хаягжилтийн хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлэхийн тулд дараах зүйлсийг хийх шаардлагатай байна. Үүнд:

- Хаягжилтийн ойлгож, замаа хэрхэн олох талаар сургалтыг хүүхэд багачуудад орох
- Хаягжилтийн хүртээмж, хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг оновчтой зохион байгуулах

#### 4. НИЙТИЙН ТЭЭВЭР

Аюулгүй орчны гол хүчин зүйлсийн нэг болох “Нийтийн тээвэр”-ийн хувьд нийт дүүргүүдийн дундаж **45%**, хар бүсэд буюу эрсдэлтэй бүлэгт багтаж байна. Хамгийн эрсдэл өндөртэй нь Багахангай дүүрэг бол бусад дүүргүүдээсээ арай бага нь Баянгол байна.

График 14. Нийтийн тээвэр - Дүүргүүдийн харьцуулалт



Хүүхдүүдийн хувьд гэр нь автобусны буудалтайгаа ойрхон гэж 73% хариулсан нь харьцангуй энэ тал дээр эрсдэл бага ч суудаг автобус нь удаан ирдэг бөгөөд нийтийн тээврээр явахад аюултай санагддаг гэж 2 хүүхэд тутмын 1 нь хариулснаас харахад нийтийн тээврийн хүртээмж, аюулгүй зорчиход эрсдэл өндөр байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 21. Нийтийн тээврийн үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт

Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
Гэр нь автобусны буудалтай ойрхон байдал	73%	63%	35%	83%	67%	43%	75%	76%	68%	75%
Суудаг автобус нь хурдан ирдэг байдал	27%	23%	18%	27%	26%	47%	28%	28%	21%	27%
Нийтийн тээврээр зорчиход аюултай санагддаггүй байдал	35%	40%	33%	34%	35%	40%	37%	36%	30%	35%
<b>Нийт дундаж</b>	<b>45%</b>	<b>42%</b>	<b>29%</b>	<b>48%</b>	<b>43%</b>	<b>43%</b>	<b>47%</b>	<b>47%</b>	<b>40%</b>	<b>46%</b>


Тиймээс цаашид нийтийн тээврийн аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд дараах зүйлсийг хийх шаардлагатай байна. Үүнд:

- Нийтийн тээврийн хаана зогсож байгааг мэдэх боломжтой Ulaanbaatar\_Bus APP ашиглан хүүхдүүд цагаа зохицуулан, удаан хүлээхгүйгээр автобусанд суух (тухайн APP-ны тухай таниулах шаардлагатай)
- Нийтийн тээврээр хүүхэд багачууд аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хүн бүр нэг нэгэндээ шаардлага тавих, хүүхэд багачуудыг хамгаалж тэднийг айдасгүй зорчих нөхцөлийг иргэн бүр ухамсарлах

## 5. ЗАМЫН ХӨДӨЛГӨӨН

Аюулгүй орчны гол хүчин зүйлсийн нэг болох “Замын хөдөлгөөн”-ийн хувьд нийт дүүргүүдийн дундаж **86%**, шар бүсэд буюу боломжийн түвшинд хамаарч байна. Замын хөдөлгөөний аюулгүй байдал хамгийн өндөртэй нь Баянгол дүүрэг бол бусад дүүргүүдээсээ арай бага нь Налайх дүүрэг байна.

График 15. Замын хөдөлгөөн - Дүүргүүдийн харьцуулалт



Замын хөдөлгөөний дүрмийн талаарх мэдлэгийн хувьд судалгаанд оролцсон хүүхдүүдийн 90% нь наад цахын энгийн ойлголттой гэж хариулсан бөгөөд зорчих замд гарц, тэмдэглэгээ ойлгомжтой байдаг эсэх дээр 82% нь тийм гэснээс харахад замын хөдөлгөөний аюулгүй байдал харьцангуй бага болохыг харуулж байна.

Хүснэгт 22. Замын хөдөлгөөний үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт

Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
Замын хөдөлгөөний дүрмийн талаар мэддэг байдал	90%	90%	80%	94%	84%	77%	90%	91%	88%	91%
Зорчих замд гарц, тэмдэглэгээ ойлгомжтой байдаг байдал	82%	84%	84%	87%	73%	75%	85%	81%	85%	80%
<b>Нийт дундаж</b>	<b>86%</b>	<b>87%</b>	<b>82%</b>	<b>90%</b>	<b>78%</b>	<b>76%</b>	<b>87%</b>	<b>86%</b>	<b>87%</b>	<b>86%</b>


Тиймээс цаашид замын хөдөлгөөний аюулгүй байдлыг нэмэгдүүлэхийн тулд дараах зүйлсийг хийх шаардлагатай байна. Үүнд:

- Зорчих замын гарц, тэмдэглэгээг илүү ойлгомжтой хүртээмжтэй болгох

## 6. ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

Аюулгүй орчны гол хүчин зүйлсийн нэг болох “Хүүхэд хамгаалал”-ийн хувьд нийт дүүргүүдийн дундаж **51%**, саарал бүсэд буюу анхаарал татахуйц хэсэгт багтаж байна. Хүүхэд хамгааллын аюулгүй байдал хамгийн өндөртэй нь Сүхбаатар дүүрэг бол бусад дүүргүүдээсээ арай бага нь Налайх дүүрэг байна.

График 16. Хүүхэд хамгаалал - Дүүргүүдийн харьцуулалт



Хүүхэд хамгааллын хувьд судалгаанд оролцсон хүүхдүүд асуудал тулгарахад сургуулийнхаа нийгмийн ажилтнаас анхан шатны тусламж авахаар 7 хүүхэд тутмын 1 нь ханддаг гэхээр тухайн ажлын байрны хүрэлцээ хангалттай биш байгааг илтгэж байна. Мөн амьдардаг хорооны зүгээс хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр тодорхой үйл ажиллагаа явуулдаг эсэх талаар 51% мэдэхгүй, 26% огт явуулдаггүй гэж хариулсан байна. Харин эцэг эх, асран хамгаалагч нарын зүгээс хүүхдийн эрх зөрчигдөхөөс сэргийлсэн мэдээлэл зөвлөгөө өгдөг байдал, эрхээ зөгчигдвөл хаана хандахаа мэддэг байдал, гамшигт тохиолдвол юу хийхээ мэддэг байдлын хувьд хүүхдүүд бүрэн дүүрэн мэдээлэлтэй байдаггүй нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Хүүхдийн тусламжийн утасны талаарх мэдлэг харьцангуй боломжийн түвшин байгаа сайн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 23. Хүүхэд хамгааллын үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт

Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
Эцэг эх, асран хамгаалагч нар хүүхдийн эрх зөрчигдөхөөс сэргийлсэн мэдээлэл зөвлөгөө өгдөг байдал	60%	59%	73%	59%	61%	66%	65%	56%	60%	58%
Эрхээ зөрчигдвөл хаана хандахаа мэддэг байдал	66%	68%	75%	65%	64%	64%	72%	63%	67%	67%
Сургуулийнхаа нийгмийн ажилтнаас тусламж авч байсан байдал	14%	23%	22%	10%	10%	55%	11%	11%	12%	13%
Хүүхдийн тусламжийн утасны талаар мэддэг байдал	83%	87%	86%	85%	78%	76%	91%	83%	83%	83%
Амьдардаг хороо хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байдал	23%	27%	35%	16%	28%	51%	25%	13%	30%	24%
Гамшиг тохиолдвол юу хийхээ мэддэг байдал	62%	63%	59%	67%	52%	63%	63%	63%	62%	63%
<b>Нийт дундаж</b>	<b>51%</b>	<b>54%</b>	<b>58%</b>	<b>50%</b>	<b>49%</b>	<b>62%</b>	<b>55%</b>	<b>48%</b>	<b>52%</b>	<b>51%</b>


Тиймээс цаашид хүүхэд хамгааллыг нэмэгдүүлэхийн тулд дараах зүйлсийг хийх шаардлагатай байна. Үүнд:

- Сургуулийн нийгмийн ажилтны хүүхдүүдтэй ажиллах хүртээмжийг нэмэгдүүлэх
- Хорооны зүгээс хүүхдүүдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа тогтмол явуулах

## 2.4 СУРЧ ХӨГЖИХ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ

Хүүхдийн сурч хөгжих орчны үнэлгээг доорх 3 дэд бүлгийн хүрээнд хэмжиж үнэлсэн. Судалгаагаар **42%** буюу хүүхэд сурч хөгжих орчин нөхцөл бүрэлдээгүй, таатай биш асуудалтай байгаа нь доорх байшингийн цонхоор илэрхийлэгдсэн өнгийн дүрслэлээс харж болно.

Зураг 7. Сурч хөгжих орчны үнэлгээ



Хүүхдийн сурч, хөгжих орчинд хамгийн их сөргөөр нөлөөлж байгаа үзүүлэлт бол “Тоглоомын талбай” болох нь цонхонд хар өнгөөр дүрслэгдсэнээр харагдаж байна. Хүүхдүүдийн нас сэтгэхүй, бие бялдарын онцлогт тохируулсан, эрүүл мэндийн чанарын шаардлага хангасан, эвдрэл гэмтэл, аюулгүй байдалд нь тогтмол хяналт тавьж, сэргээн завсарладаг төлөвлөлт, зохион байгуулалт бүхий үйл ажиллагааг хэрэгжүүлдэг тоглоомын талбайн бүтээн байгуулалт шаардлагатай байна.

Мөн цаашлаад хүүхдэд чөлөөтэй тоглох нөхцлийг бүрдүүлсэн спорт заал, хичээлээс гадуур хүүхдийг хөгжүүлэх чиг үүргийн хүрээнд ном унших таатай орчин нөхцлийг бүрдүүлэх, хүүхдийн сонирхол, авъяас чадварт тохирсон дугуйлан, секцийг бий болгох шаардлагатай байна.

Хүснэгт 24. Сурч хөгжих орчин – дүүргүүдийн харьцуулалт

Үнэлгээний үзүүлэлтүүд	Дүүргүүд									
	БНД	БХД	НД	БГД	СХД	СБД	БЗД	ЧД	ХУД	НИЙТ
1 Спорт заал	65%	87%	64%	45%	43%	40%	35%	46%	50%	<b>46%</b>
2 Тоглоомын талбай	22%	42%	38%	23%	23%	19%	18%	18%	27%	<b>23%</b>
3 Боловсрол	61%	59%	62%	58%	53%	54%	51%	56%	57%	<b>56%</b>
<b>Нийт дундаж</b>	<b>49%</b>	<b>63%</b>	<b>55%</b>	<b>42%</b>	<b>40%</b>	<b>38%</b>	<b>35%</b>	<b>40%</b>	<b>47%</b>	<b>42%</b>


Хүүхдүүдийн сурч, хөгжих таатай орчин нөхцөлийн хувьд Багахангай, Налайх, Багануур, Хан-Уул саарал буюу дунд бүсэд, харин Баянгол, Сонгонихайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх дүүргүүд хар буюу муу гэсэн үзүүлэлттэй бүсэд багтаж байна. Энэ нь хүүхдүүдийн сурч хөгжих орчины хэмжээнд нь анхаарал татахуйц түвшинд байгаагаас гадна цаашид зайлшгүй нөлөөлж

байгаа хүчин зүйлсүүдэд нь анхаарч ажиллан, сайжруулах шаардлагатай байна. Баянзүрх дүүргийн хувьд бусад дүүргүүдээсээ үзүүлэлтээрээ хамгийн бага үнэлгээтэй гарсан байна.

## 1. СПОРТ ЗААЛ

Хот суурин төвлөрсөн газрын хувьд хүүхдийг эрүүл чийрэг бие бялдартай болгон өсгөн хүмүүжүүлэх гол хүчин зүйлсийн нэг болох “Спорт заал”-ийн хүрэлцээ, хангамжийн асуудал юм. Улаанбаатар хотын нийт дүүргүүдийн хувьд спорт заалны хүрэлцээ дундаж утгаар **46%** буюу дөнгөж саарал бүсэд багтаж байгаа нь цаашид заавал зайлшгүй сайжруулах шаардлагатай анхаарал татахуйц хэсэгт байна. Ингээд дүүргүүдийг харьцуулан авч үзвэл харьцангуй ам сийрэг захын дүүргүүдийн хувьд спорт заалны хүрэлцээ арай өндөр хувьтай Багахангай дүүргийн хувьд сайн гэсэн үзүүлэлттэй, харин төвийн дүүргүүдийн хувьд ялангуяа Баянзүрх дүүргийн хувьд заал хэрэгцээтэй байгаа хүүхдүүдэд хүртээмж, нөхцөл хангалтгүй байгааг доорх графикаас харж болохоор байна.

График 17. Спорт заал - Дүүргүүдийн харьцуулалт



Эндээс гэрийн нөхцөл, амьдардаг орчны хувьд ч гэсэн хүүхдүүдэд зориулан биеийн чилээгээ гаргах, спорт тоглоом тоглох зориулалтын тоглоомын талбай хангалтгүй байгааг мөн харж болохоор байна.

Хүснэгт 25. Спорт заалны үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт


Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
Амьдардаг орчинд нь дугуй унах, спорт тоглоом тоглох талбай байдаг байдал	50%	60%	84%	53%	41%	59%	51%	41%	57%	47%
Амьдардаг орчинд спорт заал байдаг байдал	42%	69%	90%	38%	29%	68%	34%	39%	44%	46%
<b>Нийт дундаж</b>	<b>46%</b>	<b>65%</b>	<b>87%</b>	<b>45%</b>	<b>35%</b>	<b>64%</b>	<b>43%</b>	<b>40%</b>	<b>50%</b>	<b>46%</b>

Тиймээс цаашид хүүхдийг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, эрүүл чийрэг бие бялдартай болгон төлөвшүүлэхэд хүүхэд хүссэн хүүхэд бүрт чөлөөт, ижил тэгш нөхцөл боломжийг бий болгосон, дуртай спортоор хичээлэх бүрэн боломжтой, олон улсын стандарт шаардлагыг хангасан тоглоомын талбай болоод спорт заалны хүрэлцээг нэмэгдүүлэх улмаар бүтээн байгуулалт хийх шаардлагатай байгаа нь энэхүү судалгааны дүнгээс харагдаж байна.

## 2. ТОГЛООМЫН ТАЛБАЙ

Хүүхдийг бага наснаас нь төлөвшүүлэх, эрүүл чийрэг болгон өсгөхөд нас сэтгэхүйн онцлогт нь тохирсон тоглоом чухал үүрэгтэй бөгөөд нийслэлийн хэмжээнд хүүхэд бүрт ижил тэгш боломжийг олгосон зохион байгуулалт бүхий гадаа тоглох зориулалттай, эрүүл мэнд, аюулгүй байдлын шаардлагыг хангасан тоглоомын талбайн асуудал хурцаар тавигдаж байгаа **23%-ийн** буюу маш хангалтгүй үнэлгээ авсанаас нь харж болохоор байна. Ингээд нийт дүүргүүдийн хувьд тоглоомын талбайн хүрэлцээ, нөхцөл боломжийг харьцуулан Багахангай дүүргийн хувьд 42%-ийн арай өндөр үнэлгээтэй, Баянзүрх, Сүхбаатар дүүргийн хувьд 18-19 хувийн маш хангалтгүй үнэлгээтэй байгааг доорх графикаас харж болохоор байна.

График 18. Тоглоомын талбай - Дүүргүүдийн харьцуулалт



Эндээс гаднах тоглоомын талбайг бүтээн байгуулах үйл ажиллагаа, төлөвлөгөөндөө хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ээлтэй хэлбэрийг огт харгалзан үздэггүй, тоглоомын явцын хяналт, нэмэлт сайжруулалт, сэргээн засварлах ажлыг гүйцэтгэх чиг үүргийг тодорхойгүй орхигдуулдаг, тодорхой байсан ч явцын үйл ажиллагаа хэрэгжүүлэлт нь хангалтгүй байгааг дурьдах нь зүйтэй юм.

Хүснэгт 26. Тоглоомын талбайн үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт

Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
Амьдардаг орчны тоглоомын талбайд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тоглох боломжтой байдал	13%	18%	22%	12%	10%	38%	12%	12%	15%	11%
Амьдардаг орчны тоглоомын талбайг сэргээн засварладаг байдал	32%	25%	63%	35%	26%	38%	33%	27%	39%	26%
<b>Нийт дундаж</b>	<b>23%</b>	<b>22%</b>	<b>42%</b>	<b>23%</b>	<b>18%</b>	<b>38%</b>	<b>23%</b>	<b>19%</b>	<b>27%</b>	<b>18%</b>


Тиймээс цаашид хүүхэд багачуудын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангасан, хүүхдийн онцлогт тохирсон стандарт бүхий, явцын хяналт болон сэргээн засварлах ажлыг тогтмол гүйцэтгэдэг зохион байгуулалт бүхий тоглоомыг талбайг бий болгох ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх, бусад тоглоомыг талбайд хяналт хийн сэргээн засварлах ажлыг гүйцэтгэх шаардлагатай байна.



### 3. БОЛОВСРОЛ

Судалгааны үр дүнгээс нийслэлийн хэмжээнд хүүхдэд боловсрол олгож буй бодлого, чиг үүргийн хэрэгжилтийг **56%** буюу дунд түвшинд саарал бүсэд хамрагдаж байна гэсэн үзүүлэлт гарсан. Ингээд агуулгыг хувьд задлан үзвэл нийслэлийн хэмжээнд судалгаанд оролцсон хүүхдүүдийн 92% нь цэцэрлэгт хамрагдаж, 94% нь сургуульдаа тогтмол явдаг гэсэн сайн үр дүнтэй гарсан. Харин хичээлээс гадуурх хүүхдийн хөгжлийг дэмжсэн бодлого, орчин нөхцлийг харвал судалгаанд оролцсон нийт хүүхдүүдийн 50% нь хичээлээс гадуурх сонгон, дугуйланд хамрагддаг, 52% нь гэртээ өөрийн компьютертэй, 62% нь хүүхдийн эрхийн талаар мэддэг, 77% нь онлайн хичээлдээ тогтмол оролцдог байсан, 72% нь сургуульд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан шат болон ариун цэврийн өрөө байдаггүй, 44% нь ойр орчимд номын сан болон ном уншихад зориулсан газар байдаггүй хэмээн хариулсан. Мөн 18% нь сургууль дээр нь хүүхдийн оролцооны байгууллага байдаггүй, 47% нь байдаг эсэхийг ч мэдэхгүй хэмээсэн бол 64% нь амьдардаг хороо, дүүрэгт нь хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг газар байдаг эсэх талаар ямар мэдээлэл алга хэмээн хариулсан нь улсаас хүүхдийн хөгжлийн дэмжих, сурч хөгжих орчин нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаагаа, бодлого төлөвлөлт дутуу байгааг харуулж байна.

График 19. Тоглоомын талбай - Дүүргүүдийн харьцуулалт



Харин энэхүү боловсролын үзүүлэлтийг дүүрэг тус бүрээр харьцуулан үзэхэд ерөнхийдөө ойролцоо түвшинд байгаа бөгөөд Налайх дүүргийн хувьд 62% буюу арай илүү өндөр үзүүлэлттэй, Баянзүрх дүүргийн хувьд 51% буюу хамгийн бага үзүүлэлттэй гарсан байна.

Эндээс агуулгыг задлан харвал хүүхдийн цэцэрлэгт хамрагдах байдал Багахангай дүүргийн хувьд 98% гэсэн хамгийн өндөр үзүүлэлттэй, Налайх дүүргийн хувьд 69% буюу хамгийн бага, харин сургуульд тогтмол хамрагдалтын хувьд ихэнхи дүүргүүдийн хувьд 96% буюу сайн гарсан бол Налайх дүүргийн хувьд 74% буюу хамгийн бага үзүүлэлттэй гарсан бол онлайн хичээлд хамрагдалтын хувьд Баянгол дүүрэг хамгийн өндөр буюу 85%, Налайх, Багануур дүүргүүдийн хувьд 57%, 59% гэсэн хамгийн бага үзүүлэлтийг заасан байна. Мөн хичээлээс гадуурх сурагчдааа нэмэлт сонгон дугуйлан хамрагдуулах байдлын хувьд Багануур дүүрэг хамгийн өндөр буюу 65%, Сүхбаатар болон Чингэлтэй дүүргийн хувьд хамгийн бага үзүүлэлтийг илэрхийлсэн байна. Харин хүүхдийн хөгжлийг дэмжсэн, эрхийг хамгаалсан оролцооны байгууллагыг чиг үүрэг үйл ажиллагааг

тодруулах асуулгад Налайх дүүрэг 71-79% хэмээн хамгийн өндөр үнэлгээтэй эерэг хариулт өгсөн байгааг харж болохоор байна. Эндээс дүгнэн үзэхэд боловсролын орчин нөхцлийн хувьд Налайх дүүрэг бусад дүүргүүдтэй харьцуулахад өндөр үзүүлэлттэй гарсан нь тус дүүрэг хүүхдийг хамгаалах, хөгжүүлэх чиглэлийн хүрээнд үйл ажиллагаа хэрэгждэг хэмээн үзсэнтэй шууд хамааралтай гарсан байна. Нөгөөтэйгүүр тус дүүргийн хувьд хүүхдийн сургууль болон цэцэрлэгт хамрагдалтын хувьд хамгийн бага үзүүлэлттэй гарсныг анхааралдаа авч сайжруулах нь зүйтэй юм.

**Хүснэгт 27. Боловсролын үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт**

Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
Цэцэрлэгт явж байсан байдал	92%	93%	98%	96%	89%	69%	94%	91%	92%	93%
Сургуульдаа тогтмол явж чаддаг байдал	94%	95%	96%	96%	92%	74%	96%	96%	95%	96%
Амьдардаг орчинд номын сан эсвэл ном унших боломжтой газар байдаг байдал	44%	63%	75%	45%	32%	55%	38%	47%	43%	46%
Нэмэлтээр сонгон дугуйлан, секцэд хамрагддаг байдал	50%	65%	43%	57%	47%	44%	46%	42%	53%	42%
Сургуулийн орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан шат, ариун цэврийн өрөө байдаг байдал	18%	31%	16%	9%	16%	56%	10%	16%	23%	22%
Гэртээ компьютертэй байдал	52%	31%	33%	58%	49%	45%	50%	51%	55%	51%
Онлайн хичээлдээ бүрэн хамрагдаж чаддаг байдал	77%	57%	71%	85%	75%	59%	81%	72%	79%	79%
Хүүхдийн эрхийн талаар мэддэг байдал	62%	66%	59%	64%	56%	70%	66%	59%	62%	63%
Сургууль дээр хүүхдийн оролцооны байгууллага байдаг байдал	35%	55%	39%	29%	28%	71%	25%	36%	34%	37%
Хороо, дүүрэгт хүүхэд хөгжлийн төв байдаг байдал	37%	57%	61%	43%	27%	79%	29%	27%	34%	31%
<b>Нийт дундаж</b>	<b>56%</b>	<b>61%</b>	<b>59%</b>	<b>58%</b>	<b>51%</b>	<b>62%</b>	<b>53%</b>	<b>54%</b>	<b>57%</b>	<b>56%</b>

Эндээс нэгтгэн дүгнэхэд дүүргүүдийн хэмжээнд хүүхдийн хөгжлийг дэмжсэн бодлого төлөвлөлт хангалтгүй байна. ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сурах таатай орчин нөхцлийг бүрдүүлж чадаагүй, мөн хүүхдийг хөгжлийг дэмжих, хүүхдийн онцлог, авъяас чадварыг хөгжүүлэх бодлого байхгүй, хүүхдийн бие бялдарын өсөлтийг дэмжих, эрүүл ахуйн шаардлага хангасан тоглоомын талбай, спорт заалны хүрэлцээ хангалтгүй байна. Тиймээс цаашдаа хүүхдийн сурч хөгжих таатай орчин нөхцлийг хангахын тулд


- Бие бялдарын хувьд эрүүл чийрэг иргэнийг төлөвшүүлэхэд спортын төрлийг дэмждэг, дугуйланд секцийг ажиллуулдаг, хүүхэд хүссэн үедээ тоглох боломжтой спорт заалны хүрэлцээг бий болгох шаардлагатай байна
- Хүүхдийн сонирхол, авъяас чадварын онцлогт тохирсон сонгон дугуйланг сургууль орчмын бүсэд бий болгон, чөлөөтэй хамрагдах боломж бололцоог бүрдүүлэх
- Гаднах орчны тоглоомын талбайн бүрэн бүтэн байдлыг тогтмол хянадаг, сэргээн засварладаг мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан орчин нөхцлийг сайжруулах, хүүхэд бүрт боломж бололцоог ижил тэгш олгодог болгох тал дээр анхаарал хандуулах

- Хүүхдийг хөгжлийг дэмжсэн сайн дурын болоод албан ёсны оролцооны байгууллагууд, хүүхдийн хөгжлийн төвийн чиг үүргийг тодорхой болгон үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

## 2.5 ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЛЦЭЭТ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ

Хүүхдүүдийн өрхийн эдийн засгийн хувьд хүрэлцээтэй байх орчин нөхцөлийг үнэлэхдээ доорх 5 дэд бүлгийн хүрээнд хэмжиж үнэлсэн бөгөөд судалгаагаар **80%** буюу боломжийн гэсэн агуулгыг илэрхийлэгч шар бүсэд хамрагдсан байгааг доорх байшингийн цонхоор илэрхийлэгдсэн өнгийн дүрслэлээс харж болно.

Зураг 8. Эдийн засгийн хүрэлцээт орчны үнэлгээ



Нийслэлийн хэмжээнд судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 79% нь өрх гэр нь тогтмол орлоготой хэмээн үзсэн бөгөөд тус хүүхдүүдийн 91% нь хүүхдийн эрхийг зөрчсөн хөдөлмөр эрхлэдэггүй хэмээн хариулжээ. Эдгээр хүүхдүүдийн анхдагч хэрэгцээ хангагдаж буй эсэхийг тодруулан үзэхэд сургуульдаа явж, сурч боловсроход шаардлагатай ном, дэвтэр бүхий хичээлийн хэрэгслийн хэрэгцээ 94% буюу хангалттай түвшинд хангагдсан байна.

Хүснэгт 28. Эдийн засгийн хүрэлцээт орчин– дүүргүүдийн харьцуулалт

Үнэлгээний үзүүлэлтүүд	Дүүргүүд									
	БНД	БХД	НД	БГД	СХД	СБД	БЗД	ЧД	ХУД	Нийт
1 Өрхийн орлого	73%	88%	78%	82%	84%	77%	77%	74%	80%	79%
2 Хүүхдийн хөдөлмөр	90%	90%	65%	92%	91%	91%	94%	91%	91%	91%
3 Хүнс	62%	67%	65%	77%	63%	69%	65%	66%	70%	69%
4 Бичиг хэрэг	94%	94%	91%	96%	96%	94%	90%	96%	95%	94%
5 Солих хувцас	64%	59%	46%	71%	70%	70%	66%	68%	69%	68%
<b>Нийт дундаж</b>	<b>77%</b>	<b>80%</b>	<b>69%</b>	<b>84%</b>	<b>81%</b>	<b>80%</b>	<b>78%</b>	<b>79%</b>	<b>81%</b>	<b>80%</b>

Судлаачийн зүгээс эдийн засгийн орчинг өрхийн санхүүгийн байдлаар төлөөлүүлэн илэрхийлэх үзүүлэлтийг боловсруулахдаа тухайн өрх гэр нь санхүүгийн хувьд анхдагч хэрэгцээгээ хангаж чадаж буй эсэхийг тодруулахыг зорьсон бөгөөд энэхүү үзүүлэлтийн үнэлгээ нь анхдагч хэрэгцээг хангаж буй ерөнхий үнэлгээ юм.


жимс, хүнсний ногоог байнга хэрэглэх нь хүний бие махбодид чухал шаардлагатай аминдэм, эрдэс бодис, үл исэлдүүлэгч, эслэгийг агуулсан байдаг учир өдөрт байнгын хэрэглээ болговол зохилтой/ агуулга бүхий хүнсний ногоо, жимс жимсгэнэний хэрэглээг тодотгох асуулгад судалгаанд оролцсон

хүүхдүүдийн 69% нь хүнсэндээ нарийн ногоо, жимс жимсгэнэ хэрэглэдэг, 31% нь хэрэглэдэггүй хэмээн хариулсан байна. Хувцасны хэрэгцээ хангагдсан байдлыг тодотгохын тулд өвлийн хувцасны хэрэглээнд төвлөрч агуулгыг боловсруулсан бөгөөд судалгаанд оролцсон хүүхдүүдийн 68% нь өвөл сольж өмсөх хангалттай хувцастай хэмээн хариулсан байна.

## 1. ӨРХИЙН ОРЛОГО

Өрхийн санхүүгийн хүрэлцээт байдлыг хэмжих хамгийн чухал хүчин зүйлсийн нэг болох өрхийн тогтмол орлогыг тодорхойлох асуулга нь судалгааны үр дүнгээс **79%** тогтмол орлоготой хэмээн гарсан бөгөөд дүүргүүдийн хувьд харьцуулан үзэхэд Налайх дүүрэг хамгийн бага үзүүлэлттэй буюу 71%, Багахангай дүүргийн хувьд хамгийн өндөр буюу 89% ийн үзүүлэлттэй гарсан байна.

График 20. Өрхийн орлого - Дүүргүүдийн харьцуулалт



Мөн нийслэлийн хэмжээнд хүүхдийн хөдөлмөрийн тухайд авч үзвэл 91% -ийн сайн үзүүлэлттэй гарсан бөгөөд дүүргүүдийн хувьд аваад үзвэл Баянзүрх дүүрэг 94% буюу хүүхдийн хөдөлмөр эрхлэлт хамгийн багатай, Налайх дүүрэг 65% буюу тус дүүргээс судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 29% нь хөдөлмөр эрхэлдэг хэмээн хариулсан бөгөөд хүүхдийн хөдөлмөр эрхлэлт хамгийн өндөр байгаа дүүрэг хэмээн судалгааны үр дүнгээс харагдаж байна.


Хүснэгт 29. Өрхийн орлогын үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт

Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
Асран хамгаалагч гэр бүлийн гишүүд тогтмол орлоготой байдал	79%	73%	88%	82%	77%	78%	84%	77%	80%	74%
Хүүхэд хөдөлмөр эрхлэдэггүй байдал	91%	90%	90%	92%	94%	65%	91%	91%	91%	91%
<b>Нийт дундаж</b>	<b>85%</b>	<b>81,5%</b>	<b>89%</b>	<b>87%</b>	<b>85,5%</b>	<b>71%</b>	<b>87,5%</b>	<b>84%</b>	<b>85,5%</b>	<b>82,5%</b>

## 2. ХҮНС

Хүүхдийн хоол хүнсний амин дэмтэй, витаминлаг чанарыг илэрхийлэх агуулга бүхий хүнсний ногоо, жимс жимсгэнэний хэрэглээг тодотгох асуулгад нийслэлийн хэмжээнд судалгаанд оролцсон хүүхдүүдийн **69%** нь хүнсэндээ тогтмол хэрэглэдэг хэмээн хариулсан бөгөөд дүүргээр нь харьцуулан харахад Баянгол дүүрэг хамгийн өндөр үзүүлэлттэй буюу **77%**, Багануур дүүргийн хувьд хамгийн бага буюу **62%** ийн үзүүлэлттэй гарсан байна.

График 21. Хүнс - Дүүргүүдийн харьцуулалт



Эндээс дүгнэн харахад нарийн ногоо, жимсний хэрэглээний түвшин дундаж хэмжээнд байгаа бөгөөд орлогынх түвшинтэй харьцуулан үзэхэд өдөр тутамдаа нарийн ногоо, жимс хэрэглэхийг хичээдэг хэмээн хариулагсдын **85%** нь тогтмол орлоготой өрх бөгөөд эндээс энэхүү хэрэглээ нь өрхийн орлогын түвшингээс шууд хамааралтай болох нь илт харагдах юм.

Хүснэгт 30. Хүнсний үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт


Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
Гэр бүл хүнсэндээ тогтмол нарийн ногоо, жимс жимсгэнэ хэрэглэдэг байдал	69%	62%	67%	77%	65%	65%	63%	69%	70%	66%
<b>Нийт дундаж</b>	<b>69%</b>	<b>62%</b>	<b>67%</b>	<b>77%</b>	<b>65%</b>	<b>65%</b>	<b>63%</b>	<b>69%</b>	<b>70%</b>	<b>66%</b>

Тиймээс цаашид хүүхэд багачуудын хүнсний бүтээгдэхүүний зохистой хэрэглээ болоод нарийн ногоо, жимс жимсгэнэ, сүү, сүүн бүтээгдэхүүний ач холбогдлыг ухуулан таниулах, ойлголт мэдээлэл олгох нь зүйтэй юм.

### 3. БИЧИГ ХЭРЭГ

Хүүхэд сурч хөгжихөд шаардлагатай наад захын бичгийн хэрэгслийн хэрэгцээ хангагдах байдлын хувьд нийслэлийн хэмжээнд **94%** -ийн буюу сайн гэсэн үзүүлэлттэй гарсан.

График 22. Бичиг хэрэг - Дүүргүүдийн харьцуулалт



Дүүргүүдийн бичиг хэргийн хэрэглээ хангагдсан байдлаг харьцуулан үзэхэд харьцангуй ойролцоо үр дүнтэй гарсан бөгөөд Баянзүрх дүүргийн хувьд 90% буюу хамгийн бага үнэлгээг илтгэсэн байна.


Хүснэгт 31. Бичиг хэргийн үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт

Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
Сургуульд хэрэглэх үзэг цаас, ном дэвтэр хүрэлцээтэй байдал	94%	94%	94%	96%	90%	91%	96%	94%	95%	96%
<b>Нийт дундаж</b>	<b>94%</b>	<b>94%</b>	<b>94%</b>	<b>96%</b>	<b>90%</b>	<b>91%</b>	<b>96%</b>	<b>94%</b>	<b>95%</b>	<b>96%</b>

### 4. СОЛИХ ХУВЦАС

Хүүхэд хэвийн хэмжээнд өсч хөгжихөд эдийн засгийн орчин чухал үүрэгтэй бөгөөд үүнийг өрхийн анхдагч хэрэгцээ хангагдаж буй байдлаар төлөөлүүлэн судлахыг оролдсон бөгөөд хүүхдийн сольж өмсөх хувцасны хэрэгцээ хангагдсан байдлын хувьд **68%** буюу шар бүсэд хамаарч байна.

График 23. Солих хувцас - Дүүргүүдийн харьцуулалт



Харин дүүргүүдийн хувьд харьцуулан үзэхэд Налайх дүүргийн хувьд 46% буюу хамгийн бага үнэлгээг илтгэсэн бөгөөд өвлийн цаг сольж өмсөх хувцас хангалттай бус даарах магадлал өндөр байна хэмээн харж болохоор байна.

**Хүснэгт 32.** *Хувцас солих үзүүлэлтүүд – Дүүргүүдийн харьцуулалт*

Үзүүлэлтүүд	Нийт	БНД	БХД	БГД	БЗД	НД	СХД	СБД	ХУД	ЧД
Өвлийн улиралд сольж өмсөх ээлжийн гуталтай байдал	68%	64%	59%	71%	66%	46%	70%	70%	69%	68%
<b>Нийт дундаж</b>	<b>68%</b>	<b>64%</b>	<b>59%</b>	<b>71%</b>	<b>66%</b>	<b>46%</b>	<b>70%</b>	<b>70%</b>	<b>69%</b>	<b>68%</b>

Эндээс дүгнэн үзэхэд нийслэл хотод амьдарч буй өрх айлуудын анхдагч хэрэгцээ 80%-тай хангагдаж байгаа бөгөөд цаашид иргэдийн тогтмол орлогын түвшинг алдагдуулахгүй байхад анхааран, улмаар орлогын хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь зүйтэй бөгөөд ингэснээр бусад үзүүлэлт болох хэрэглээний түвшин уялдаа холбоотойгоор сайжрах боломжтой юм.

## ДҮГНЭЛТ САНАЛ ЗӨВЛӨМЖ



### Саарал түвшин

Нийслэлийн хүүхдэд ээлтэй орчны нэгдсэн үнэлгээ **59%** буюу саарал бүсэд хамаарч байгаа бөгөөд энэхүү бүс нь үнэлгээний хувьд дунд буюу цаашид сайжруулах шаардлагатай байгааг илэрхийлж байна. Тиймээс анхаарал татсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаанд төвлөрч ажиллах шаардлагатай бөгөөд ажлын үр дүнгээс хамааран шар түвшинд шилжих боломжтой юм.

Зураг 9 Хүүхдэд ээлтэй орчны нэгдсэн үнэлгээ



Хүүхдэд ээлтэй орчны үнэлгээг үзүүлэлт тус бүрээр нь нэгтгэн дүгнэвэл

### Эрүүл амьдрах орчин

Хүүхдийн эрүүл амьдрах орчны үзүүлэлтүүдийн дундаж нь **55%** буюу дунд гэсэн үнэлгээтэй гарсан бөгөөд анхаарвал зохих үзүүлэлтийг авч үзвэл иргэдийн дунд эмийн зохистой хэрэглээ 54% буюу алдагдсан дур мэдэн эм хэрэглэх тохиолдол өндөр, өсвөр насны хүүхдүүдийн дунд ДОХ болон БЗХӨ-ний талаарх мэдээлэл ойлголт 41% буюу хангалтгүй байна. Мөн нийслэлийн хувьд ил задгай хог хаягдал 68% -тай буюу хог ихтэй, иргэдийн хувьд хогоо ангилж хаях байдал 39% буюу дадал



суугаагүй, агаарын бохирдолын үзүүлэлт 49%, хөрсний бохирдол 51% буюу асуудал байна гэсэн үр дүн гарсан бөгөөд эдгээр асуудлуудын нийлэн хүүхдийн эрүүл амьдрах орчинд сөргөөр нөлөөлж байна хэмээн үзэж байна.

### **Сэтгэл зүйн орчин**

Сэтгэл зүйн орчны хувьд **57%** буюу сэтгэл зүйн орчин нөхцөл таатай биш асуудалтай гэсэн үр дүн гарсан бөгөөд анхаарвал зохих үзүүлэлтүүдийг авч үзвэл хүүхдүүдийн дунд интернэт болон гар утас ашиглалтын өндөр хувьтай байгаа бөгөөд үүнд эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс тавих хяналтыг сайжруулах шаардлагатайн харуулж байна. Мөн хүүхдийн ойр орчим архи, согтууруулах ундаа хэрэглэх, хэтрүүлэн хэрэглэсэн хүмүүстэй таарах байдал 65% буюу их, хүүхдүүд сургуулийн орчимд бие биеэ дээрэлхэх байдал 36%, үгээр хэлээр гутаан доромжлох байдал 48%, зодуулж, гэмтэх байдал 34% буюу 3 хүүхэд тутмын нэгэнд тохиолдох магадлалтай. Харин тухай хүүхдийн хувьд 42% нь үгээр хэлээр доромжлуулж байсан, 13% нь хэн нэгэнд зодуулж байсан, 8% нь бэлгийн дарамтад өртөж байсан хэмээн үзсэн байна. Мөн хүүхэд харилцаа төлөвшилийн хувьд 53%-ийн дунд гэсэн үзүүлэлттэй байгаа бөгөөд судалгаанд хамрагдсан 2 хүүхэд тутмын нэг нь өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чаддаггүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ялгавалан гадуурхалгүй харьцах байдал 38% буюу хангалтгүй, 50% нь тэдэнтэй хэрхэн харьцах талаар ямар ч ойлголт байхгүй гэсэн байгаа зэрэг нь асуудал байгааг илэрхийлж байгаа бөгөөд эдгээр асуудлуудын нийцэл нь хүүхэд сэтгэл зүйн орчинд сөргөөр нөлөөлж, зөв хүн болон төлөвшихөд саад учруулж байна хэмээн үзэж байна.

### **Аюулгүй амьдрах орчин**

Хүүхдийн аюулгүй амьдрах орчин судалгаагаар **59%** буюу аюулгүй амьдрах орчин нөхцөл таатай биш асуудалтай гэсэн үнэлгээтэй гарсан бөгөөд анхаарвал зохих үзүүлэлтүүдийг авч үзвэл хаягжилтын байдал 42% буюу хангалтгүй, хүүхэд түүнийг ойлгон ашиглах байдал 0% буюу маш муу боломжгүй гэсэн үр дүн гарсан. Мөн хүүхэд нийтийн тээврээр зорчиход аюулгүй байдал 43% буюу хангалтгүй үүнээс хамгийн өндөр үзүүлэлттэйгээр буюу 42% нь автобус маш удаан хүлээдэг, 48% нь нийтийн тээврээр зорчиход аюултай санагддаг гэсэн байна. Мөн хүүхдийн хамгааллын хувьд 53% ийн дунд гэсэн үзүүлэлттэй гарсан бөгөөд үүнээс 82% нь сургуулийн нийгмийн ажилтанаас ямар нэгэн тусламж үйлчилгээ авч байгаагүй, 77% харьяа хороо дүүргийн зүгээс хүүхэд хамгааллын чиглэлээр ямар нэг үйл ажиллагаа хэрэгжүүлдэг талаар огт мэдээлэл байхгүй хэмээн үзжээ.

### **Сурч, хөгжих орчин**

Хүүхдийн сурч хөгжих орчин буюу боловсрол олгож буй бодлого, чиг үүргийн хэрэгжилтийг **42%** буюу хангалтгүй байна хэмээн үнэлсэн бөгөөд анхаарал татсан асуудлыг нэгтгэн үзвэл ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сурах таатай орчин нөхцлийг 18% буюу бүрдүүлж чадаагүй хэмээн үнэлсэн бөгөөд 56% нь хүүхдийг хөгжлийг дэмжих, хүүхдийн онцлог, авъяас чадварыг хөгжүүлэх

бодлого байхгүй, хүүхдийн бие бялдарын өсөлтийг дэмжих, эрүүл ахуйн шаардлага хангасан тоглоомын талбай, спорт заалны хүрэлцээ хангалтгүй байна. Тиймээс цаашдаа хүүхдийн сурч боловсрох таатай орчин нөхцлийг хангахын тулд зөвхөн оюуны боловсролд анхаарахаас гадна бие бялдарын хөгжил болоод тоглоомын талбайн бүрэн бүтэн байдлыг тогтмол хянадаг, сэргээн засварладаг болгох мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан орчин нөхцлийг сайжруулах, хүүхэд бүрт боломж бололцоог ижил тэгш олгодог болгох тал дээр анхаарал хандуулах мөн хүүхдийг хөгжлийг дэмжсэн оролцооны байгууллага болон хүүхдийн хөгжлийн төвийн чиг үүргийг тодорхой болгон үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна. Мөн хүүхдийн сонирхол, авъяас чадварын онцлогт тохирсон сонгон дугуйланд хамрагдах боломж бололцоог бүрдүүлэх өгөх нь зүйтэй байна

### **Эдийн засгийн хүрэлцээт орчин**

Эдийн засгийн хүрэлцээт орчны үзүүлэлт **80%** буюу боломжийн түвшинд байна гэсэн үзүүлэлттэй гарсан. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн 79% нь өрх гэр нь тогтмол орлоготой хэмээн үзсэн бөгөөд тус хүүхдүүдийн 69% нь хүнсэндээ нарийн ногоо, жимс жимсгэнэ хэрэглэдэг, 25% нь хэрэглэдэггүй хэмээн хариулсан байна. Хувцасны хэрэгцээ хангагдсан байдлыг тодотгохын тулд өвлийн хувцасны хэрэглээнд төвлөрч агуулгыг боловсруулсан бөгөөд судалгаанд оролцсон хүүхдүүдийн 68% нь өвөл сольж өмсөх хангалттай хувцастай, 22% нь хангалттай бус хэмээн хариулсан байна. Энэхүү үзүүлэлт нь зөвхөн өрхийн анхдагч хэрэгцээ хангагдсан байдлыг илэрхийлж буй гэдгийг тодотгон үзэх шаардлагатай бөгөөд цаашид иргэдийн тогтмол орлогын түвшинг алдагдуулахгүй байхад анхаарах улмаар орлогын хэмжээг нэмэгдүүлэх, нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй бөгөөд ингэснээр бусад үзүүлэлтүүд уялдаа холбоотойгоор сайжрах бүрэн боломжтой юм.

### **САНАЛ ЗӨВЛӨМЖ**

Нийслэлийн хэмжээнд хүүдэд ээлтэй орчин нөхцлийг илүү сайжруулахын тулд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байгааг судалгаанд үр дүнд тулгуурлан дэвшүүлж байна. Үүнд

1. Орчны хог хаягдал, агаарын бохирдол, хөрсний бохирдлыг даван туулах туушдаа үр дүнтэй арга хэмжээг шат дараалалтай зохион байгуулах, тухайлбал хөрсний бохирдлоос сэргийлэхийн тулд ОО-ийн бохирыг заавал соруулдаг байлгах чиглэлд анхаарал хандуулах, ногоон байгууламж, ногоон тохижилтын аяныг эрчимтэй өрнүүлэх, айл өрхүүдэд бохирдлоос сэргийлэх учирч болох хор уршигыг таниулах, сэргийлэх зорилгоор ашиглаж болох хялбар арга зөвлөмжийг хүргүүлэх, сурталчилан таниулах ажлыг зохион байгуулах мөн иргэдийг хог болон угаадасаа ил задгай хаяхгүй байхад тавих хяналтыг сайжруулах, хогоо хогийн саванд хаях, ангилж хаях тал дээр соён гэгээрүүлэх аяныг өрнүүлэх улмаар зөв

- дадал, соёлыг төлөвшүүлэх үр дүнтэй аргыг санаачлан, бүх нийтэд соёл болоод соён гэгээрүүлэх хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлдэг байх
2. Хаягжилтын зохион байгуулалтыг цэгцтэй хүүхэд ойлгон, ашиглахад хялбар байхаар төлөвлөн хэрэгжүүлэх, ойлгон ашиглахад чиглэсэн мэдээлэл олгох сургалтыг зохион байгуулах
  3. Хүүхдийн бие бялдар, нас сэтгэхүйн онцлогт тохирсон дахин сэргээгддэг, бүрэн бүтэн байдалд хяналт тавьдаг тоглоомын талбайн стандартыг мөрдүүлэн ажиллах
  4. Хүүхэд чөлөөтэй бие бялдараа хөгжүүлэх спорт тоглоомоор хичээллэх боломжийг олгосон олон улсын стандарт нийцсэн спорт заалыг бүтээн байгуулах, нийтэд хүртээмжтэй байлгах төлөвлөгөөт ажлыг хэрэгжүүлэх
  5. Хүүхдийг нээлттэй үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж сургахад төлөвшүүлэх, багш нар болон эцэг эхчүүдийн зүгээс шаардлагатай дэмжлэгийг олгодог байх
  6. Хүүхэд архи болон согтууруулах ундаатай холбоотой сэтгэл зүй болоод бие махбодийн хувьд хохирол амсах, бусдад уруу татагдах эрсдэл байна гэсэн үр дүн гарсантай холбогдуулан хүүхдэд согтууруулах ундаа болон мансууруулах бодисын хор уршиг, аюулыг сурталчилан таниулж, мэдээлэл хүргэх, хүүхдэд зохих ёсны мэдээлэлтэй болсоноор өөрөө хэрэглэх, бусдад уруу татагдах эрсдлийг бууруулах, аюултай нөхцөл байдлаас зайлсхийж сурах, мөн хүүхдийн хүрээлэнд архи болон мансууруулах бодисны хэрэглээг илрүүлэх, эрт таслан зогсоох арга хэмжээг авахад хувь нэмэр оруулах бүрэн боломжтой юм.